



ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр
эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл
2021 он

Г.Цэвээндорж (Төсөв, санхүүгийн зөвлөх)



2021 он

Агуулга

Товчилсон үгс	1
1. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлого ба Тогтвортой хөгжлийн зорилго	5
1.1. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх НҮБын ТХЗ болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.....	5
1.2. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын хөтөлбөрт суурилсан төсөвлөлт, түүний хэрэгжилтийн байдал	10
1.2.1. Төсвийн төлөвлөлт	10
1.2.2. Төсвийн хэрэгжилт	11
1.2.3. Төсвийн гүйцэтгэл, тайлагнал	11
1.2.4. Зөвлөмж	13
2. Монгол улс болон бусад улс орны хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд олгож буй төсвийн санхүүжилтын харьцуулалт.....	13
3. Хөдөлмөрийн салбарын зарлагын шинжилгээ	14
3.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах хөдөлмөрийн салбарын хөтөлбөр	15
3.2.Хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн биелэлт, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ .	16
3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт улсын төсвөөс олгож буй зарлагын макро-эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй харьцуулсан харьцуулалт.....	18
3.4. Хөдөлмөрийн салбарын зарлагын бүтэц.....	21
3.4.1. Хөдөлмөр эрхлэлт	25
3.4.2. Мэргэжлийн боловсрол, сургалт.....	26
3.4.3. Хөрөнгө оруулалт.....	28
4. Хөдөлмөрийн салбарын төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ.....	31
5. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын үр дүнгийн шинжилгээ.....	32
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ.....	35
6.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого	35
6.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрүүд, тэдгээрийн зарлагын үр ашиг, үр дүнгийн шинжилгээ	37
6.2.1. ХЭДС-гийн нийт зарлагад хийсэн шинжилгээ.....	39
6.2.2. ХЭДС-гийн санхүүжилттэй хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт иргэдийн тоонд шинээр бий болсон ажлын байрны тооны эзлэх хувь хэмжээ, үр дүн	41
6.2.3. Хөтөлбөрүүдийн зарлагын үр ашгийн тооцоо.....	42
6.2.3.1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр..	43

6.2.3.2.	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр.....	43
6.2.3.3.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр.....	44
6.2.3.4.	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	45
6.2.3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	46
6.2.3.6.	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	49
6.3.	Жижиг зээл.....	50
6.4.	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	51
7.	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилтэд хийсэн үр дүн, үр ашгийн шинжилгээ.....	55
7.1.	Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудад улсын төсвөөс олгож буй санхүүжилтийн үр дүнд хийсэн шинжилгээ	56
	Дүгнэлт.....	64
	ХАВСРАЛТ 1. ТХЗ, “АЛСЫН ХАРАА-2050”, ТӨСВИЙН ХАВСРАЛТ 1 ДЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ	68
	Ашигласан Материал.....	70

Товчилсон үгс

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕХ	Европын холбоо
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МТБСБ	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
СЯ	Сангийн яам
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөл
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага

Зураг

Зураг 1. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд төсвөөс олгож буй санхүүжилт (хөдөлмөрийн салбарт олгож буй санхүүжилтыг ДНБ-д харьцуулсан хувиар, 2018 оноор).....	14
Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодит зарлага (тэрбум төгрөг).....	19
Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын ДНБ-д эзлэх хувь	19
Зураг 4. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлага болон эдийн засгийн өсөлт хоорондын хамаарал.....	20
Зураг 5. Хөдөлмөрийн салбарын зарлагын нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь ..	21
Зураг 6. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц, 2010-2021 (тэрбум төгрөг)..	22
Зураг 7. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц(эдийн засгийн ангилалаар)..	23
Зураг 8. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц	24
Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлага, тусгай ангилалаар, тэрбум төгрөг ...	24
Зураг 10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.....	25
Зураг 11. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хэрэгжилт, удирдлага болон бусад арга хэмжээ	26
Зураг 12. Мэргэжлийн боловсролын байгууллагуудын төсвийн зарлагын чиг хандлага	27
Зураг 13. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарлагын чиг хандлага ..	28
Зураг 14. Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалт.....	28
Зураг 15. Хөрөнгө оруулалт, зориулалтаар (сая төгрөг)	30
Зураг 16. Хөрөнгө оруулалт, эдийн засгийн ангилалаар (сая төгрөг)	30
Зураг 17. Хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөгөөболон гүйцэтгэлийн зөрүү хувь хэмжээ	32
Зураг 18. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон ажилгүйдлийн түвшин хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар)	33
Зураг 19. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар).....	33
Зураг 20. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон шинээр бий болсон ажлын байрны тоо хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар).....	34
Зураг 21. Шинээр бий болсон ажлын байрны тоо болон ажлын байртай болсон МТБСБ-ийн төгсөгчийн тооны ажилгүй хүний тоонд эзлэх хувь.....	35
Зураг 22. Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого, гадаад иргэдийн тоо, хөдөлмөрийн хөлсний тоо хэмжээ	37
Зураг 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлага болон шинээр бий болсон ажлын байрны хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хүний тоогоор)	39
Зураг 24. ХЭДС-ийн 6 хөтөлбөрүүдийн нийт зардал (сая төгрөг) болон бий болсон ажлын байр	40
Зураг 25. Хөтөлбөрүүдийн санхүүжилтийн өөрчлөлт болон бий болсон ажлын байрны өөрчлөлт (өөрчлөлтийн хувиар)	41
Зураг 26. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	43
Зураг 27. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	44
Зураг 28. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр.....	45
Зураг 29. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	46

Зураг 30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс орох орлого, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зарлага болон эдгээрийн хоорондын харьцаа	47
Зураг 31. Аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт хамрагдсан иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо болон эдгээрийн хоорондын харьцаа	48
Зураг 32. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	49
Зураг 33. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	50
Зураг 34. Жижиг зээлийн өөрчлөлтийн хувь	51
Зураг 35. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, нэг хүнд ногдох зардлын өөрчлөлтийн хувь (2016-2020)	52
Зураг 36. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” болон “Ажилд зуучлах үйлчилгээ”-ний зардал (сая төгрөг)	53
Зураг 37. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д олгож буй санхүүжилт болон хамрагдсан хүний тоо, (сая төгрөг)	53
Зураг 38. “Ажилд зуучлах үйлчилгээ”-хамрагдсан иргэдийн тоо болон зарцуулсан хөрөнгө (сая төгрөг).....	54
Зураг 39. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” болон “Ажилд зуучлах үйлчилгээ”-д хамрагдсан нэг иргэнд ногдох зардлын хэмжээ (төгрөг).....	54
Зураг 40. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох зардлын өөрчлөлт (мянган төгрөгөөр).....	56
Зураг 41. Төсвийн санхүүжилт болон ажлын байртай болсон төгсөгчдийн хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, төгсөгчдийн тоогоор)	57
Зураг 42. Төсвөөс олгож буй санхүүжилтийн өөрчлөлт болон ажлын байртай болсон төгсөгчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар)	58
Зураг 43. Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй нийт санхүүжилт болон нийт төгсөгчдийн тоонд ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний хоорондын хамаарал	59
Зураг 44. Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй нийт санхүүжилтийн өөрчлөлтийн хувь болон нийт төгсөгчдийн тоонд ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний өөрчлөлтийн хувийн хоорондын хамаарал	59
Зураг 45. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д олгож буй урсгал зарлага болон суралцагчдын тооны хоорондын хамаарал	60
Зураг 46. Төсвийн санхүүжилтийн өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар)	61
Зураг 47. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсад болон суралцагчийн тооны хоорондын хамаарал (хүний тоогоор)	62
Зураг 48. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсдын өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар).....	63
Зураг 49. Суралцагчийн тоо болон суралцагчид сард олгох тэтгэлгийн хэмжээний өөрчлөлтийн хоорондын хамаарал (хүний тоо, төгрөгөөр).....	64

Хүснэгт

Хүснэгт 1. ТХЗ 8-Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго	6
Хүснэгт 2. “Алсын хараа-2050”-ийн 2. Хүний хөгжил, 3. Амьдралын чанар ба дундаж давхарга, хэсэгт туссан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлт	7
Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлогын баримт бичигт тусгасан үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт.....	9
Хүснэгт 4. Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд туссан үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулсан харьцуулалт.....	9
Хүснэгт 5. Хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн ангилал.....	15
Хүснэгт 6. Хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн хувь (биелэлтийг төлөвлөгөөнд харьцуулсан хувиар).....	17
Хүснэгт 7. ХЭДС-ийн орлогын бүтэц, сая төгрөгөөр	36
Хүснэгт 8. Хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд ажлын байртай болсон хүмүүсийн эзлэх хувь	42
Хүснэгт 9. Жижиг зээлтэй холбоотой үндсэн мэдээлэл.....	50
Хүснэгт 10. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө.....	51

1. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлого ба Тогтвортой хөгжлийн зорилго

Тогтвортой хөгжлийн үндсэн зорилго (ТХЗ) бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино. Энэ зорилгод хүрэх хамгийн чухал арга зам нь уг ТХЗ-ыг Монгол Улсын хөгжлийн бодлого болон салбарын бодлоготой нягт уялдуулах явдал юм. Монгол Улсын Засгийн газар, Европын холбоо (ЕХ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-өөс ТХЗ-д нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулах замаар үр дүн, нотолгоонд суурилсан төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, тайлагнах тогтолцоо бүхий төсөв, санхүүгийн зохистой удирдлагыг нэвтрүүлэхээр зорьж байна. ТХЗ, төрийн бодлогыг төсвийн бодлогоор дамжуулан амжилттай хэрэгжүүлэхэд Сангийн яам (СЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), бусад салбарын яамдын бодлогын болон санхүү, эдийн засгийн газрууд, яамд хоорондын зохицуулалт, хамтын ажиллагаа ихээхэн үүрэгтэй юм.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогын зорилгыг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний дагуу тус салбарын зарлагын шинжилгээг гүйцэтгэж, үр дүнг энэхүү тайланд тусгав. Төсвийн зарлагын шинжилгээнд холбогдох төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн тоон мэдээллийг СЯ-аас, хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, өгөгдлийг ХНХЯ, түүний харья байгууллагуудаас, зарим үр дүнгийн мэдээллийг Үндэсний Аудитын Газар (ҮАГ), Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээллийн цахим сангаас тус тус авч ашигласан.

Энэхүү тайлангийн эхний хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлогын уялдаа, бодлогын шинжилгээний үр дүн, дараагийн хэсэгт хөдөлмөрийн салбарын төсвийн зарлагын хандлага, үр ашгийн шинжилгээний үр дүнг өгүүлэв. Мөн салбарын хөрөнгө оруулалтын байдлыг хамруулав. Эцэст нь хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн дүн шинжилгээнд үндэслэн төсвийн харилцааг сайжруулах, цаашид бодлого, арга хэмжээндээ анхаарах, хэрэгжүүлэх дүгнэлтийг өгсөн.

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх НҮБ-ын ТХЗ болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Тогтвортой хөгжлийн зорилго

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас 17 зорилго, 169 зорилттой “Тогтвортой хөгжлийн зорилго – 2030” баримт бичгийг 2015 онд баталж, 2016 оны 1 сарын 1-ээс албан ёсоор дэлхий даяар хэрэгжүүлж эхэлсэн¹. Мөн 2017 оны 3 сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна (ҮСХ).

Уг 17 зорилгоос хөдөлмөр эрхлэлтийн салбарт шууд хамаарах зорилго нь ТХЗ 8 буюу Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго, шууд бус дам хамаарах ТХЗ 1 буюу Ядуурлыг устгах зорилго тус тус болно. Харин ТХЗ 3.8.2, ТХЗ 5.4.1, ТХЗ

¹ <https://sdgs.un.org/2030agenda>

9.2.2, ТХЗ 10.2.1, ТХЗ 11.1.1 дүгээр зорилгуудын цөөхөн хэсэг нь нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлтэй холбоотой салбар дундын зорилгууд байна.

Хүснэгт 1. ТХЗ 8-Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго

№	ЗОРИЛТ, ХҮРЭХ ТҮВШИН	ҮЗҮҮЛЭЛТ
1	Зорилт 8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих	8.3.1 Хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлтэд албан бус секторын ажил эрхлэлтийн эзлэх хувь, хүйсээр
2	Зорилт 8.5 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнтэй ажилд адилхан цалин хөлс олгох	8.5.1 Эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж хөлс, ажил мэргэжлээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр
		8.5.2 Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр
3	Зорилт 8.6 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах	8.6.1 Боловсрол эзэмшээгүй, хөдөлмөр эрхлээгүй болон сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь
4	Зорилт 8.7 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох	8.7.1 Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр
5	Зорилт 8.8 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүх ажил хөдөлмөр эрхлэгчид, түүний дотор улирлын түр ажилтан, ялангуяа улирлын түр эмэгтэй ажилтан, аюултай хөдөлмөр эрхэлдэг ажилтнуудад аюулгүй, найдвартай ажиллах орчныг бий болгох	8.8.1 Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь, хүйсээр, цагаачлалын байдлаар
		8.8.2 Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж болон үндэсний хууль тогтоомжид үндэслэн гарах эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээртэй холбоотой хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн түвшин
6	Зорилт 8.b 2020 он гэхэд залуучуудын ажил эрхлэлтийн дэлхийн стратегийг боловсруулан хэрэгжүүлж, ОУХБ-ын Ажил хөдөлмөрийн дэлхийн гэрээ хэрэгжүүлэх	8.b.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний стратегийн хүрээнд эсвэл тусад нь боловсруулан хэрэгжүүлж байгаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний стратегитай эсэх
7	Зорилт 10.1 2030 он гэхэд бага орлоготой хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр түвшинд аажмаар хүргэж, хадгалах	10.1.1 Хүн амын нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн хүн амын орлого, зарлагын эзлэх хувийн жингийн өөрчлөлт (өсөлт)
8	Зорилт 10.4 Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах	10.4.1 ДНБ-нд цалин, нийгмийн хамгааллын шилжүүлгийн эзлэх хувь

Эх сурвалж: ҮСХ, <https://sdg.1212.mn/Home/Detail?id=8>

ҮСХ-ны үзэж буйгаар ТХЗ 8-ийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой үзүүлэлтүүдийн дийлэнх нь гарах боломжтой бөгөөд зөвхөн ТХЗ 8.8.1 дүгээр үзүүлэлтийг одоогоор гаргахгүй байгаа талаар дурдсан байна (ҮСХ).

“Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын Хараа-2050” нь хөдөлмөр эрхлэлтийн салбарын шууд зорилгыг Бүлэг 2. Хүний хөгжил, Бүлэг 3. Амьдралын чанар ба дундаж давхарга, Бүлэг 4. Эдийн засаг -т тус тус тодорхойлсон. Тухайлбал, Хөдөлмөрийн зах зээл 2.6 дэд бүлэгт “Хөдөлмөрийн эдийн засгийн

тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно”, Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес 3.3 дэд бүлэгт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ”, Чинээлэг монгол 4.1. дэд бүлэгт -т “Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдсэн байна” гэж тус тус тодорхойлсон байна.

“Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дурдсан хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд харьцангуй цөөн тоотой буюу үндсэн 5 үзүүлэлттэй байгаа бөгөөд ТХЗ-д туссан үзүүлэлттэй зөвхөн 1 үзүүлэлт ижил, бусад үзүүлэлт нь хоорондоо уялдахгүй байна. Тухайлбал, ТХЗ 8.5.2-ийн “Ажилгүйдлийн түвшин” үзүүлэлт нь “Алсын Хараа-2050” болон Төсвийн хуулийн Хавсралт 1 (Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт)-ийн шалгуур үзүүлэлттэй ижил байна.

Харин “Алсын Хараа-2050”-д туссан 1 үзүүлэлт нь Төсвийн хуулийн Хавсралт 1-тэй ижил, 2 үзүүлэлт нь ХНХЯ-ны Нийгмийн даатгал болон Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй төстэй, 2 үзүүлэлт нь өөр байна. Харин ҮСХ-оос гаргах боломжтой Ажиллах хүчний оролцооны түвшин, Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь нь Төсвийн хуулийн Хавсралт 1-т тусгагдаагүй байна.

ТХЗ, “Алсын хараа-2050”, Төсвийн хуулийн Хавсралт 1-д туссан үзүүлэлтийн харьцуулсан хүснэгтийг Хавсралт 1-ээс үзэх боломжтой юм.

Хүснэгт 2. “Алсын хараа-2050”-ийн 2. Хүний хөгжил, 3. Амьдралын чанар ба дундаж давхарга, хэсэгт туссан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Төсвийн хуулийн Хавсралт 1
				2025	2030	2050	
1	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	84.4	90	99	100	Төстэй
2	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	61	63	65	70	Өөр
3	Ажилгүйдлийн түвшин	хувь	8.6	7.8	7	3	Ижил
4	Нийт төгсөгчид ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль)	хувь	76.5	90	95	100	Төстэй
5	Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь	хувь	71.6	80	85	95	Өөр

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11059?lawid=15406>

ТХЗ-ийн хөдөлмөр эрхлэлтийн шалгуур үзүүлэлтүүд нь илүү дэлгэрэнгүй буюу жендер, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, цалингийн зөрүү, амьдралын чанарын үзүүлэлт зэрэг тэгш байдлыг илүү чухалчилсан байна. Харин “Алсын Хараа-2050”-д жендер, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар товчхон байдлаар тусгасан боловч шалгуур үзүүлэлтдээ энэ талаар дурдаагүй байна.

Өөрөөр хэлбэл “Алсын Хараа-2050”-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой олон зорилт, заалт орсон хэдий ч шалгуур үзүүлэлт хэсэгт цөөн тооны үзүүлэлтийг багтаасан байна. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх “Алсын Хараа-

2050”-гийн үндсэн хөтөлбөрт туссан зорилго, зорилтууд нь ТХЗ-ын зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй бүрэн болон зарим талаар нийцэж байна. Харин “Алсын Хараа-2050”-д ТХЗ 8.6, 8.7, 8.8 дахь зорилтуудтай уялдсан хөгжлийн бодлогын зорилго, зорилтууд байхгүй байна.

Хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг үр дүнтэй болгох, зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход ТХЗ, “Алсын хараа-2050” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг хооронд нь нягт уялдуулах шаардлагатай байна. Мөн ТХЗ, “Алсын хараа-2050” хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиудын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан хөдөлмөр эрхлэлтийн үндэсний бодлого, хөтөлбөрүүд, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, төсвийн төсөвт тусгах, хэрэгжилт, гүйцэтгэлд **явцын хяналт тавих, тайлагнал, үр дүнд эцсийн үнэлгээ хийх үр дүнтэй, цогц системийг бий болгох нь зүйтэй байна.**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах нь ХНХЯ-ны үндсэн үүрэг хэдий ч хөдөлмөр эрхлэлтийг зөвхөн төсвөөр дамжуулж бүрэн дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжгүй юм. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд салбар дундын өөр олон байгууллагуудын үндсэн үүрэг, оролцоо чухал юм.

Хөдөлмөрийн салбарын бодлогын баримт бичигт туссан үндсэн үзүүлэлтийн биелэлт, ТХЗ, Алсын Хараа-2050 болон Төсвийн хуулийн Хавсралт-1-тэй уялдсан байдал

Өнөөдрийн байдлаар Засгийн газраас баталсан хөдөлмөрийн салбарт мөрдөгдөж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих тусдаа бодлогын баримт бичиг хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр бодлогын баримт бичгийн бусад хөгжлийн бодлогын баримт бичигтэй хэрхэн уялдаж байгаа талаар товч авч үзлээ.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” хөтөлбөрт туссан үндсэн үзүүлэлт, ТХЗ, Алсын хараа-2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, Төсвийн хуулийн хавсралт-1-ийн үзүүлэлтүүд нь хоорондоо уялдаа багатай байгаа нь доорх Хүснэгтээс харагдаж байна. ТХЗ-д ажилгүйдлийн түвшин, болон шинэ ажлын байр бий болгох талаар тусгайлан тогтоосон тоон үзүүлэлт байдаггүй. Алсын Хараа-2050 хөтөлбөр, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд “Ажилгүйдлийн түвшин”-ий 2025 онд хүрэх зорилтод түвшин 7.8 хувь байхаар авсан байхад “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” хөтөлбөрт 2025 оны зорилтод түвшин 5 хувь байхаар, 2020 оны зорилтод түвшин тус хөтөлбөрт 5.6 хувь байхаар авсан байна.

Мөн Төсвийн хуулийн Хавсралт-1-т 2020 оны ажилгүйдлийн түвшин 7.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байгаа нь “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” хөтөлбөрийн 5.6 хувийн зорилтод түвшинтэй зөрчилдөж байна.

Эндээс харахад Алсын хараа-2050 хөтөлбөрийн зорилтод түвшин нь өмнө батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээс эрс зөрүүтэй байна. Харин өнөөгийн ажилгүйдлийн түвшин, Төсвийн хуулийн Хавсралт-1-т туссан үзүүлэлттэй ойролцоо гарч байна.

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлогын баримт бичигт тусгасан үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт

Үзүүлэлт	ТХЗ	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (ЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоол)		Алсын Хараа-2050	Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр	Төсвийн хуулийн хавсралт 1	
		2020 оны зорилтот түвшин	2025 оны зорилтот түвшин				2025 оны зорилтот түвшин	2025 оны зорилтот түвшин
Ажилгүйдлийн түвшин	Ерөнхий заалт туссан	5.6	5	7.8	7.8	х	7.6	9.5

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/12035>

Засгийн газрын 2016 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг хөтөлбөрт туссан шалгуур үзүүлэлтийг ТХЗ, Алсын хараа-2050, Төсвийн хуулийн Хавсралт-1-т туссан үзүүлэлттэй харьцуулан үзлээ.

“Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх 2019 оны зорилтод түвшин 65 хувь байхаар тогтоож байсан боловч Төсвийн хуулийн хавсралтад дурдсан гүйцэтгэлээр 58.1 хувь болж зорилтод түвшинд хүрээгүй байна. Харин “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2021 оны зорилтод түвшин 70 хувь буюу Төсвийн хуулийн Хавсралт-1-т туссан 67.5 хувь гэсэн зорилтод түвшинтэй ойролцоо түвшинд байна.

Алсын Хараа-2050 хөтөлбөрт ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх 2025 оны зорилтод түвшин 90 хувь гэж авсан байгаа нь өнөөгийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн ажлын байртай болж байгаа өнөөгийн бодит статистик мэдээллээс илүү өндөр түвшин байна. **Ойрын 5 жилийн дотор төрөөс ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувийг өнөөгийн бодит түвшин болох 67.5 хувиас 90 хувьд хүргэх нь ихээхэн хүчин чармайлт шаардсан зорилт болох нь тодорхой харагдаж байна.**

Иймд уг зорилтод хүрэхийн тулд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын чанар, үр дүн, төсвийн бодлого, төлөвлөлт, харилцааг эрс сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 4. Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд туссан үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулсан харьцуулалт

Үзүүлэлт	ТХЗ	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2016 оны 304 тогтоол)	Алсын Хараа-2050	Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	Төсвийн хуулийн хавсралт 1
----------	-----	---	------------------	---	----------------------------

	Зорилтод түвшин	2019 оны зорилтод түвшин	2021 оны зорилтод түвшин	2025 оны зорилтод түвшин	2025 оны зорилтод түвшин	2019 оны гүйцэтгэл	2021 оны зорилтод түвшин
Ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь	X	65	70	90	90	58.1	67.5

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/12062>

Дээрх бодлогын баримт бичигт туссан үндсэн үзүүлэлтийн уялдаа, биелэлт, хэрэгжилт, төсөөллөөс харахад үндсэн үзүүлэлтүүд хоорондоо уялдаа султай, хэрэгжилтийн байдалд явцын болон эцсийн үнэлгээг тогтмол хийдэггүй, аливаа бодлогын шийдвэр гаргахдаа өмнөх шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг харгалзаж үздэггүй байна.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын хөтөлбөрт суурилсан төсөвлөлт, түүний хэрэгжилтийн байдал

Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2011 онд батлагдаж, 2013 оноос эхлэн хөтөлбөрт суурилсан төсөв, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тоо болон чанарын үзүүлэлтээр батлан хэрэгжүүлсээр даруй 9 жил болсон байна. Хөдөлмөрийн салбарын хөтөлбөр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг 2013 онд анх боловсруулж, УИХ-аар төсвийн хуулийн хавсралт болгон баталснаас хойших төсвийн үйл явц, хэрэгжилт, хүрсэн үр дүнг авч үзье.

1.2.1. Төсвийн төлөвлөлт

Төсвийн хуулийн дагуу ХНХЯ-аас 2021 оны төсвийн төслийг боловсруулан хөдөлмөрийн салбарын холбогдох төсвийн тооцоолол, танилцуулгыг СЯ-д хүргүүлсэн ч хөтөлбөр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн талаар тайлбар, танилцуулгадаа тусгаагүй, төсвийн зарлагын төлөвлөлттэй уялдуулаагүй байна. Тухайлбал, ТЭЗ нь Төсвийн тухай хуулийн 14.2.2 дах заалтын дагуу эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох, 22.2.4, 27.1.5 дах заалтын дагуу төсвийг хөтөлбөрийн ангиллаар төлөвлөх, 24.6 дах заалтын дагуу хэрэгжүүлэх хөтөлбөрийн урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, 31.1.2 дах заалтын дагуу төсвийн төлөвлөлтийг хийхдээ хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх, 31.4.6 дах заалтын дагуу төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоог хийсэн байх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Харин төсвийн төслийн хавсралтаар хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийг СЯ-д хүргүүлсэн байна.

ХНХЯ-аас ирүүлсэн төсвийн төслийг СЯ хянах үедээ хөдөлмөр эрхлэлтийн салбарт хамаарах хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг төсвийн эх үүсвэртэй уялдуулах, өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулах, холбогдох дүгнэлт хийсэн эсэх нь тодорхойгүй байна. СЯ улсын төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн **32.2.11** дэх заалтын дагуу хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Хавсралт 1-д тусган УИХ-д хүргүүлж байгаа боловч хөтөлбөр тус бүрийн тайлбар, танилцуулгыг хуулийн дагуу УИХ-д өргөн барьдаггүй байна. Тухайлбал, УИХ-д өргөн барьсан сүүлийн 3 жилийн төсвийн төсөл буюу 2019-2021 оны төсвийн төслийн танилцуулгыг үзэхэд хөдөлмөрийн салбараар зогсохгүй бүх салбарын хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, төсвийн эх үүсвэрийн талаар мэдээлэл, танилцуулга байхгүй байна. Үүнээс үзэхэд Төсвийн тухай хуулийн хөтөлбөрт суурилсан

төсвийн талаарх заалтын хэрэгжилт, ач холбогдол, тулгарч буй асуудал бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг бүхэлд нь авч үзэх шаардлага байна.

Засгийн газраас тухайн жилийн төсвийн төслийн Хавсралт 1-д хөдөлмөрийн салбарын хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг УИХ-д өргөн барьж, Төсвийн тухай хуулийн 33.2.5 дахь заалтын дагуу батлуулж байгаа ч УИХ хэлэлцүүлгийн шатанд **төсвийн зарлагыг хөтөлбөр, түүний үр дүнтэй уялдуулан авч үзэж, хэлэлцэж байгаа нь тодорхойгүй байна.**

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн үр дүн ямар түвшинд байгааг тодорхойлох зорилгоор УАГ-аас Монгол Улсын 2018, 2019, 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг авч үзлээ. 2018, 2021 оны төсвийн төсөлд хийсэн аудитад хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлттэй холбоотой ямар нэг дүгнэлт, зөвлөмж байсангүй. Харин 2019 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтэд “Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг эдийн засгийн зардлын зүйл ангитай уялдуулан хүрэх үр дүн бодлого чиглэлийг баримталсан төсвийн төслийг боловсруулж байх” гэсэн зөвлөмжийг өгсөн байна. **Энэ нь 2019-2021 оны төсвийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барихдаа хөтөлбөр, түүний зарлагын тооцооллын талаар танилцуулга, тайлбар хийхээ больсонтой холбоотой байх талтай байна.**

1.2.2. Төсвийн хэрэгжилт

Төсвийн жилийн явцад УИХ-аас эдийн засгийн хүндрэлтэй байдлаас улбаалан төсвийн тодотголыг хийх үед төсвийн зарлагыг тодорхой хэмжээгээр бууруулж батлахдаа Хавсралт 1-д туссан **хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг өөрчилж байгаагүй байна.** Тухайлбал, 2013 оноос хойш төсвийн тодотгол хийн төсөв бууруулах арга хэмжээг авсан хэдий ч хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд ямар нэг өөрчлөлт ороогүй байна. **Энэ нь төсвийн зарлагыг нь хөтөлбөр, түүний үр дүнтэй уялдуулахгүй байгааг илэрхийлж байна.**

Төсвийн тухай хуулийн 41.2.7, 69.1 дэх заалтуудын дагуу бүх шатны төсвийн захирагч, хяналт шинжилгээ, дотоод аудитын алба хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллахаар заасан. Гэтэл хөдөлмөрийн асуудал эрхэлсэн ТЕЗ-ын хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн биелэлт, хэрэгжилтэд 2018 он хүртэл **хяналт, шинжилгээ үнэлгээ хийж байгаагүй байна. Харин 2019 оноос эхлэн Төсвийн хуулийн Хавсралт 1-д туссан хөтөлбөрийн зорилтот түвшний биелэлт, гүйцэтгэлд хяналт, шинжилгээ үнэлгээг хийж эхэлжээ.**

1.2.3. Төсвийн гүйцэтгэл, тайлагнал

Төсвийн тухай хуулийн 14.2.6 дах заалтын дагуу ХНХЯ-аас хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2019, 2020 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн биелэлт, хүрсэн үр дүнгийн тайланг Хавсралт 1-ийн дагуу гарган санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн хамт хавсралтаар хүрүүлсэн байна. Уг тайланд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын багцын хөтөлбөрийн биелэлтийг 2019 оны дунджаар 87 хувь, 2020 оны дунджаар 92 хувь гэж дүгнэсэн байна. **Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 4 үзүүлэлтийн биелэлт 2019 онд 62.5, 2020 онд 77.5 хувь, Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн 2 үзүүлэлтийн биелэлт 2019 онд 85 хувь, 2020**

онд 85.0 хувь буюу нийт хөтөлбөрийн биелэлтийн дундаж хэмжээ болон бусад хөтөлбөрийн биелэлтээс доогуур хувьтай байна.

ҮАГ-аас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хийсэн 2016-2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг нягтлан үзэхэд 2016, 2018, 2019 онд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөтөлбөр, хүрэх үр дүн, биелэлтийн талаар дүгнэлт, тайлбар, зөвлөмжийг огт өгөөгүй байна. Зөвхөн 2017 оны аудитын тайланд хөтөлбөрийн хэрэгжилт, хүрсэн үр дүнд товч тайлбар, үнэлгээг хийсэн байна. Гэсэн ч “Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрсэн үр дүн, үндсэн үзүүлэлтийн талаар тухайлбал, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлтийн биелэлтийн талаар ямар нэг дүгнэлт, тайлбар хийгээгүй байна. байна. ***Иймд ҮАГ-аас хөдөлмөрийн салбарын төсвийн гүйцэтгэлийн аудитыг хийхдээ хөтөлбөр, түүний хүрсэн үр дүн, нөлөөлөл, хөтөлбөрийн зарлагын үр ашиг, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй дүгнэлт, зөвлөмж өгч байх шаардлагатай байна.***

Төсвийн тухай хуулийн 54.5.1 дэх заалтын дагуу СЯ-аас зөвхөн хөтөлбөрийн гүйцэтгэл, хүрсэн үр дүнгийн товч мэдээллийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нараас хүлээн авч нэгтгэн УИХ-д хүргүүлж, батлуульж байгаа ч **хөтөлбөр, хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар, тухайлбал зорилтот түвшиндээ хүрээгүй хөтөлбөрийн шалтгаан, үндэслэл, төсвийн үр ашиг, үр дүнгийн үзүүлэлтийг тайлбарласан дэлгэрэнгүй, танилцуулга, дүн шинжилгээг хийдээгүй байна.** Мөн УИХ төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ хөтөлбөрийн хүрсэн үр дүн, түүний зарлага, тэдгээрийн ын уялдааг өгүүлсэн мэдээллийг тайланд тусгахыг шаардахгүй, ҮАГ-ын аудитын дүгнэлтийг хэлэлцэхгүй Төсвийн хуулийн хэрэгжилтэд ач холбогдол өгөлгүй баталж байна.

ҮАГ 2017-2019 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ хөтөлбөрт суурилсан төсвийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаар дүгнэлт хийж, зөвлөмж өгч байсан байна (ҮАГ, 2017, 2018, 2019).

Тухайлбал, ҮАГ-ын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд доорх дүгнэлт хийсэн байна. Үүнд:

- ТЕЗ-дын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнах асуудал хангалтгүй;
- Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй ;
- Нэгтгэсэн хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг ТЕЗ-аар тайлагнасан боловч түүнд хөтөлбөр, арга хэмжээнд хамаарах төсөв, гүйцэтгэлийн дүнг арга хэмжээ тус бүрээр иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнээгүй;
- 2017 оны зорилтот түвшний хэрэгжилт тасарсан болон давуулан биелүүлсэн шалтгааныг дурдаагүй; .
- эдийн засгийн ангиллаар гаргасан төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлтэй уялдуулан тайлагнах журам, арга зүй хангалтгүй; .
- Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөж, үр дүнг тооцож хэрэгжүүлэх үйл ажиллагаа жигд бус, төлөвлөлт, бүртгэл тооцоо, тайлагналын программ хангамжийн уялдаа хангалтгүй байгаагаас ТЕЗ-ын төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдаагүй;

- ТЕЗ-д нь тухайн жилийн төсөвт өөрчлөлт оруулж зохицуулалт хийсэн гүйцэтгэлээ анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнаагүй;
- ТЕЗ-ийн хөтөлбөр арга хэмжээний төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэлтэй уялдуулах арга аргачлалыг тусгасан журам боловсруулж хэрэгжүүлэх;

ҮАГ-ын 2018 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд:

- Зарим ТЕЗ-д хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүнг төсөвтэй уялдуулан тайлагнаагүй;

ҮАГ-ын 2019 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд:

- Зарим ТЕЗ хөтөлбөр, арга хэмжээний хүрэх түвшин, хэрэгжих хугацаа, шалгуур үзүүлэлт зэргийг оновчтой төлөвлөөгүй, хэт ерөнхий байдлаар тусгажээ;
- ТЕЗ-д төсвийн хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, үр дүнгийн танилцуулгыг бэлтгээгүй, төсвийн зарлагын бодит хэмнэлтийг тооцоогүй байна;
- ТЕЗ-ын 2019 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийг СЯ-нд ирүүлснийг хянан дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх ажил хангалтгүй байна;

1.2.4. Зөвлөмж

Өнөөгийн байдлаар хөдөлмөрийн салбарын хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт, тайлагнал хангалтгүй байна. Хөдөлмөрийн салбараар хязгаарлагдахгүй бүх салбарын хөтөлбөр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, хөтөлбөр-төсвийн уялдааг төсвийн харилцааны бүх шатанд боловсронгуй болгож сайжруулах шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Цаашид хөтөлбөр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хэрхэн төсөвтэй нягт уялдуулах, хэрэгжилтийг хэрхэн сайжруулах, хяналт тавих үйл ажиллагаа, тайлагналыг хэрхэн боловсронгуй болгох талаар ХНХЯ, СЯ, ҮАГ, УИХ хамтран ажиллах шаардлагатай байна.


2. Монгол улс болон бусад улс орны хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд олгож буй төсвийн санхүүжилтийн харьцуулалт

Монгол Улсын төсвөөс хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгож буй төсвийн санхүүжилт 2018 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид, ДНБ)-ний 0.51² хувийг эзэлж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудын төсвийн санхүүжилттэй харьцуулж үзэхэд Монгол Улс нь АНУ, Польш, Япон, Чили, Чех зэрэг цөөн тооны улсын хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд улсын төсвөөс зарцуулж буйгаас илүү зарцуулж байгаа ч бусад гишүүн орнуудаас бага байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хөдөлмөрийн зах зээлийг дэмжих төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх дундаж хувь 2018

² Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөдөлмөрийн зах зээлийн төсвийн санхүүжилтийг тооцох аргачлалаар ажилгүйдлийн даатгал, тэтгэмжийг оруулан тооцдог тул Ажилгүйдлийн даатгалын сангийн 2018 оны зарлагыг оруулан тооцсон. Мөн уг тооцоонд төсвөөс мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зориулалтаар олгосон санхүүжилтийг оруулсан тооцсон.

оны байдлаар 1.16 байгаа нь Монгол Улсын ДНБ-д эзлэх төсвийн санхүүжилтээс 0.65 пунктээр илүү байна.

Зураг 1. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд төсвөөс олгож буй санхүүжилт (хөдөлмөрийн салбарт олгож буй санхүүжилтийг ДНБ-д харьцуулсан хувиар, 2018 оноор)



Эх сурвалж: ЭЗХАХБ <https://data.oecd.org/socialexp/public-spending-on-labour-markets.htm>

3. Хөдөлмөрийн салбарын зарлагын шинжилгээ

Хөдөлмөрийн салбарт төрөөс олгож буй санхүүжилт, зарлагын чиг хандлагыг тодорхойлохдоо тухайн салбарт зориулан баталсан төсөв, төсвийн гүйцэтгэл, зэрэгцүүлсэн болон оны үнээр тооцсон ДНБ, нэгдсэн төсвийн нийт зарлага, харьяалах сайдын багцын хөтөлбөр, арга хэмжээ болон бусад эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглав.

Хөдөлмөрийн салбарын зарлагын шинжилгээг хийхэд шаардагдах төсвийн зарлагын мэдээллийг цуглуулах, нэгтгэх, тодорхойлоход тодорхой хүндрэл үүссэн. Тухайлбал, Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор хөдөлмөрийн салбарын төсөв нь

нэг багцаас нөгөө багцад шилжих үйл явцтай холбоотой юм. Хөдөлмөрийн салбарын төсөв нь 2008-2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад, 2012-2016 онд Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад, 2016 оноос өнөөг хүртэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад хамаарч байна.

Төсвийн зарлагын шинжилгээнд сүүлийн 10 гаруй жил буюу 2010-2021 оны хөдөлмөрийн салбарын мэдээллийг ашиглав. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн төлөвлөлтийн мэдээллийн программ хангамж Fiscal-аас төсвийн төлөвлөлтийн мэдээллийг, Төсвийн хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын мэдээллийн сангаас хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг, Төрийн сангийн газраас төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн арга хэмжээний товч тоон мэдээллийг, Үндэсний статистикийн хорооны цахим хуудаснаас макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг, Үндэсний аудитын газар болон shilendans.gov.mn цахим хуудаснаас аудитын дүгнэлтийг, холбогдох хууль эрх зүйн мэдээллийг legalinfo.mn хуулийн мэдээллийн сангаас тус тус авч ашиглав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, хөдөлмөрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, төсөл болон хөрөнгө оруулалтын мэдээллийг нэгтгэн энэхүү зарлагын шинжилгээг хийхэд ашиглалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг шууд болон шууд бусаар дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд голлон оролцох бусад салбар, ТЕЗ нарын хөтөлбөр, зардлыг хамруулаагүй болно. Нийгмийн халамж болон даатгалын сангийн зарлагыг уг шинжилгээнд мөн хамруулаагүй болно.

3.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах хөдөлмөрийн салбарын хөтөлбөр

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д тусгаснаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад бие даасан 8 хөтөлбөр, 25 шалгуур үзүүлэлт байна. Эдгээр хөтөлбөрөөс хөдөлмөрийн салбарт бүрэн хамаарах хөтөлбөр 4, нийгмийн хамгааллын бусад салбартай хамтран хэрэгжүүлэх 1 хөтөлбөр байна.

Хүснэгт 5. Хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн ангилал

№	Хөтөлбөр	Үзүүлэлтийн тоо
1	Хөтөлбөр 27.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	2
2	Хөтөлбөр 27.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	4
3	Хөтөлбөр 27.6. Мэргэжлийн Боловсрол	2
4	Хөтөлбөр 27.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2
5	Хөтөлбөр 27.8. Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, шинжилгээ	1
	Нийт	11

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн хавсралт , <https://www.legalinfo.mn/annex/details/11371?lawid=15726>

Жилийн төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтийг баталж байгаа ч батлагдсан төсөвтэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхой бус байна. Дээр тэмдэглэсэнчлэн төсөв батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад хөтөлбөрийн зорилт, өртөг, зардал, хүрэх үр дүнг уялдуулж байгаа нь хангалтгүй байна.

Хөдөлмөрийн салбарын хөтөлбөр тус бүрийг нягтлан үзлээ.

- **“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага”** хөтөлбөр нь захиргааны шинжтэй үйл ажиллагаа, түүний зардлыг агуулж байна. Тухайлбал, ХНХЯ-ны зарим зардал болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн төсөв багтаж байна. **Харин хөдөлмөрийн салбарын бодлогыг хэрэгжүүлдэг ХХҮЕГ, орон нутаг дахь ХХҮГ зэрэг байгууллагын удирдлагын зардал уг хөтөлбөрт тусгагдаагүй байна.** Хөдөлмөр болон халамжийн бие даасан чиг үүргийг нэг байгууллага хэрэгжүүлж байгаа тохиолдолд зардлыг хэрхэн хөтөлбөр хооронд хуваарилж байгаа нь тодорхойгүй байна. Өнөөгийн байдлаар ХХҮЕГ, орон нутаг дахь ХХҮГ-ийн төсвийг “Нийгмийн халамж” хөтөлбөрт багтаан төсөвлөж, тайлагнаж байгаа нь Төсвийн тухай хуультай зөрчилдөж байна. ХНХЯ-тай хэлэлцсэний үндсэн дээр энэхүү төсвийн шинжилгээнд тодорхой таамаглал дэвшүүлж дээрх байгууллагын хөдөлмөрийн салбарт хамаарах төсвийг тооцсон болно. **Цаашид Төсвийн хуулийн шаардлагын дагуу аливаа зардлыг хамаарах Хөтөлбөрийн ангиллын дагуу төсөвлөн тайлагнаж байх шаардлагатай байна.**
- **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-г ХЭДС, хөдөлмөрийн судалгаа, ХНХЯ-ны хөдөлмөрийн чиг үүрэгт хамаарах зардал багтаж байна.**
- Бие даасан хөтөлбөр болох “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”, “Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, шинжилгээ” гэсэн хоёр хөтөлбөр холбогдох зардалтайгаа хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.
- “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрт мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд болон үнэлгээний байгууллагын төсөв хамаарч байгаа нь уг хөтөлбөрт зардалтайгаа шууд уялдаж байна.
- ***Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн зарлага нь хөдөлмөрийн салбарын хөтөлбөртэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.***

Үүнээс үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн салбарын хөтөлбөр, түүнд хамаарах зардлын уялдааг сайжруулах, хөтөлбөрийн нийт зардал, урсгал зардал, хөрөнгийн зардал, гадаад эх үүсвэрээс санхүүжих хөрөнгийг уялдуулах нь чухал байна.

3.2. Хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн биелэлт, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ

Хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, үр дүн нь тоон үзүүлэлтэд суурилсан тул биелэлтийг төлөвлөгөөтэй харьцуулж судаллаа.

Ажилгүйдлийн түвшин 2015, 2016, 2019 онд төлөвлөсөн зорилтод түвшнээс 13.7,21.1 болон 25 хувиар тус тус хэтэрч, зорилтод түвшинд хүрч буураагүй байна. Харин 2017,

2018, 2020 онд ажилгүйдлийн түвшин зорилтод түвшнээс доогуур буюу 14.1 хувь, 21.4 хувь болон 2.6 хувиар тус тус буурсан байна. Ажилгүйдлийн түвшний 2015-2020 оны дундаж өөрчлөлт 3.6 хувиар зорилтод түвшнээс өндөр буюу ажилгүйдэл төлөвлөснөөс их нэмэгдсэн, хүрэх үр дүнгийн төлөвлөгөө болон биелэлтийн хэлбэлзэл 0.19, хоорондын хамаарлын коэффициент **-0.45** буюу урвуу хамааралтай гарч байна. Өөрөөр хэлбэл, 2015-2020 оны хооронд ажилгүйдлийн түвшин гүйцэтгэлээр зорилтод түвшнээс өндөр байсан нь тодорхой харагдаж байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2015 онд 41.1 хувиар, 2016 онд 41.3 хувиар, 2019 онд 2.7 хувиар, 2020 онд 6.9 хувиар зорилтод түвшнээс тус тус бага гүйцэтгэлтэй гарч, зорилтод түвшинд хүрээгүй байна. Харин 2018 онд 3.4 хувиар, 2019 онд 3.6 хувиар зорилтод түвшнээс өндөр гүйцэтгэлтэй гарсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн зорилтод түвшний 2015-2020 оны дундаж өөрчлөлт 14.2 хувиар өндөр буюу хөдөлмөр эрхлэлт төлөвлөснөөс их буурсан, хүрэх үр дүнгийн биелэлтийн хэлбэлзэл 0.21, хоорондын хамаарлын коэффициент **-0.17** буюу урвуу хамааралтай байна. Тухайлбал, 2015-2020 оны хооронд хөдөлмөр эрхлэлтийн түвшин зорилтод түвшиндээ хүрч чадаагүй байна.

2015-2020 онд шинээр бий болсон ажлын байрын тоо 2015 онд төлөвлөсөн хэмжээнээс 1.4 хувиар давж биелсэн боловч, 2016-2020 онд төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Шинээр бий болсон ажлын байрны тооны 2016-2020 оны дундаж өөрчлөлт 21.6 хувиар зорилтод түвшинд хүрээгүй, биелэлт хангалтгүй түвшинд байсан байна. Мөн хугацаанд төлөвлөгөө, гүйцэтгэлийн хоорондын хэлбэлзлийн хэмжээ 0.13 байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэний тоо мөн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, биелэлт хангалтгүй байгааг Хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн хувь (биелэлтийг төлөвлөгөөнд харьцуулсан хувиар)

№	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	Дундаж	Стандарт хазайлт	Хамаарлын Коэффициент
	Хөтөлбөр 27.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих									
1	Ажилгүйдлийн түвшин /хувиар/	13.7%	21.1%	-14.1%	-21.4%	25.0%	-2.6%	3.6%	0.19	-0.45
2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	-41.1%	-41.3%	3.4%	3.6%	-2.7%	-6.9%	-14.2%	0.21	-0.17
3	Шинээр бий болсон ажлын байрын тоо /мянган хүн/	1.4%	-31.0%	-30.5%	-32.5%	-16.8%	-20.5%	-21.6%	0.13	0.76
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэний тоо /мянган хүн/	-25.9%	-81.7%	27.1%	-55.6%	0.0%	-89.5%	-37.6%	0.46	0.61
	Хөтөлбөр 27.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох									
1	Хөдөлмөрийн аюул ослын буурсан хувь (Ажлын байран дахь үйлдвэрлэлийн ослын бууралт /өмнөх жилд харьцуулсан хувиар-2017 оноос хойш хөтөлбөрийн нэр ийм болж өөрчлөгдсөн байна, 2020 оноос уг үзүүлэлт Хавсралт-1-ээс хасагдсан)	60.0%	13.3%	-100.0%	390.0%	-723.3%		-72.0%	4.07	0.19
2	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн ажлын байрны тоо						7.8%			
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан норм, стандартын тоо	20.0%	0.0%	-20.0%	-33.3%	0.0%	0.0%	-5.6%	0.19	0.95

	Хөтөлбөр 27.8. Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, шинжилгээ									
1	Хөдөлмөрийн салбарын хүрээнд хийгдсэн судалгааны тоо	25.0%	0.0%	50.0%	-33.3%	-16.7%	0.0%	4.2%	0.30	0.00
	Хөтөлбөр 27.6. Мэргэжлийн Боловсрол									
1	Мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөгчдийг ажлын байраар хангах /хувиар/	-5.5%	-4.2%	-28.8%	-4.3%	-11.3%	-23.1%	-12.9%	0.11	-0.14
2	Мэргэжлийн боловсролын байгууллагын дадлагын болон сургалтын баазыг шинэчлэх /тоогоор/	90.0%	-64.0%	-27.0%	-5.0%	0.0%	0.0%	-1.0%	0.51	0.45

Эх сурвалж: ХХҮЕГ, ҮСХ, *legalinfo.mn*, *mergejl.mn*, СЯ

Хөдөлмөрийн аюул ослын буурсан хувь 2015-2019 онд их хэмжээгээр хэлбэлзсэн байна. Тухайлбал, стандарт хазайлт 4.07 гарсан бөгөөд аюул ослын хэмжээ 2015 онд 60 хувь, 2016 онд д 13.3 хувиар тус тус өссөн бол 2017 онд 100 хувиар буурсан, 2018 онд 390 хувиар өссөн, 2019 онд 723 хувиар буурсан байна. **Хөдөлмөрийн аюул, осол 2015-2019 оны хооронд дунджаар 72 хувиар буурсан байна. Уг үзүүлэлт нь ТХЗ-ын 8.8.1-д заасан шалгуур үзүүлэлттэй нягт уялдаж байсан үзүүлэлт бөгөөд 2020 оны төсвийн жилээс эхлэн Төсвийн хуулийн Хавсралт-1-ээс хассан байна. Иймд уг үзүүлэлтийг ТХЗ-той уялдуулан эргэн Төсвийн хуулийн Хавсралт-1-т нэмж оруулах нь зүйтэй юм.**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдийг ажлын байраар хангах шалгуур үзүүлэлтийн хүрэх үр дүн 2015-2020 оны хооронд зорилтод түвшинд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэхээр байна. Тухайлбал, 2015-2020 оны хооронд дундаж өөрчлөлт 12.9 хувиар зорилтод түвшнээс бага, хэлбэлзэл 0.11 гэж гарсан байна. Хамаарлын коэффициент -0.14 буюу төгсөгчдийг ажлын байраар хангах төлөвлөгөө болон гүйцэтгэл хоорондоо урвуу хамааралтай гэж гарч байна.

Цаашид хөтөлбөрийн төлөвлөлтийг сайжруулах, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бодитой төлөвлөх, төсөвлөлттэй уялдуулах, хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээг хийх, дотоод аудит хийх, жилийн эцэст хүрсэн үр дүнг төлөвлөгөөтэй харьцуулан шинжлэх, хэрэгжилтийг дэлгэрэнгүй тайлагнах, танилцуулах шаардлагатай байна.


Мөн мэдээлэл, өгөгдлийн найдвартай, үнэн зөв, ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байна. Хөдөлмөрийн зах зээл, мэргэжлийн боловсролын мэдээллийн нэгдсэн системтэй болох, хөдөлмөрийн зах зээл, техникийн болон мэргэжлийн боловсролын чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, гадаад, дотоод санхүүжилтээр хийсэн судалгаа, мэдээллийг нэгтгэн оруулах шаардлагатай байна. Мэдээллийн нэгдсэн системтэй болсон тохиолдолд иргэд, их, дээд сургуулийн багш, оюутан, ХНХЯ, ХХҮЕГ, ХХҮГ-ын холбогдох мэргэжилтнүүд аливаа судалгаа шинжилгээ хийх, өдөр тутмын ажилдаа ашиглах боломж бүрдэх юм.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт улсын төсвөөс олгож буй зарлагын макро-эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй харьцуулсан харьцуулалт

Хөдөлмөрийн салбарын нийт зарлагад ХНХ-ын сайдын багцын хөдөлмөрийн салбарт хамаарах урсгал болон хөрөнгийн зардал, гадаад зээл тусламжийг хамруулан тооцлоо. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох дэд хөтөлбөрүүдийн санхүүжилтэд хуваарилсан зарлагыг хамруулаагүй болно.

ХНХСайдын төсвийн багцын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төсвийн зарлага харьцангуй бага дүнтэй байна. Уг зарлагын нөхцөл байдал, чиг хандлагыг судлахдаа инфляцтай уялдуулсан бодит зарлагыг тооцсон.

Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодит зарлага (тэрбум төгрөг)




Эх сурвалж: СЯ, УСХ

Зураг 2-д харуулснаар 2010-2021 оны хооронд хөдөлмөрийн салбарын дундаж бодит зарлагын өсөлт 13.8 хувь буюу харьцангуй өндөр өсөлттэй байна. 2010-2014 оны хооронд бодит зарлагын өсөлт жилийн 9-84 хувийн өсөлттэй байсан ч 2015-2017 онд жилд 5-18 хүртэл хувиар огцом буурч, 2018 онд өсөөгүй байна. Харин 2019 оноос эхлэн бодит өсөлт бий болж байгаа нь Зураг21-ээс тодорхой харагдаж байна.

Хэдийгээр сүүлийн 12 жилийн дундаж бодит өсөлт харьцангуй өндөр байгаа ч (Зураг 2) **бодит өсөлтийн хувь ерөнхийдөө ялимгүй буурах чиг хандлагатай байна.** Хөдөлмөрийн салбарын бодит зарлагын өөрчлөлтийн хувь хэт өндөр хэлбэлзэлтэй буюу **стандарт хазайлт нь 27** хувь байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2011-2015 онд тогтвортой 0.6-0.9 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол 2016-2019 онд 0.4-0.5 хувь болж буурчээ (Зураг 3). Хөдөлмөрийн салбарын зарлагын ДНБ-д эзлэх дундаж хувийг сүүлийн 12 жилээр авч үзэхэд 0.63 хувь байна. Хөдөлмөрийн салбарын зарлагын ДНБ-д эзлэх хувь 2010-2020 оны хооронд ихээхэн хэлбэлзэлтэй, **стандарт хазайлт 22 хувь** байна.


Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, ҮСХ

Зураг 3-оос харахад ДНБ өсөж байхад хөдөлмөр эрхлэлтийн зарлагын ДНБ-д эзлэх хувь буурах чиг хандлагатай байна. Буурсан үндсэн шалтгааныг нарийвчлан авч үзэхийн тулд эдийн засгийн өсөлт болон зарлагын өсөлтийн хоорондын хамаарлыг харьцуулж үзлээ.

Зураг 4. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлага болон эдийн засгийн өсөлт хоорондын хамаарал



Эх сурвалж: СЯ, ҮСХ

Эдийн засгийн өсөлт болон хөдөлмөрийн салбарын зарлагын өөрчлөлт хооронд эерэг хамаарал буюу хамаарлын коэффициент **0.5** байна. Эдийн засгийн өсөлт хамгийн өндөр


буюу 17.5 хувь байсан 2011 онд хөдөлмөрийн салбарын зарлага 84 хувь өссөн байна. 2009 онд батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан (цаашид МБСДС)-д хөрөнгө хуваарилж, ХЭДС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн нь ихээхэн нөлөөлсөн байна. 2011-2014 онд эдийн засгийн өсөлт жилд 8.1-17.5 хувь буюу өндөр өсөлттэй байх үед хөдөлмөрийн салбарын зарлага жилд 9-84 хувиар өссөн байна.

Харин 2014 оноос дэлхийн зах зээл дээр манай улсын экспортын гол нэрийн түүхий эд болох зэс, нүүрсний үнэ огцом унаснаас эдийн засгийн өсөлт саарсан. 2015 онд эдийн засгийн өсөлт 2.5 хувь, 2016 онд 1.5 хувь хүрч саарсан байна (Дэлхийн Банк). Эдийн засгийн хүндрэл үүссэнтэй холбогдуулан УИХ-ын 2015 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын дагуу Засгийн газар төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийн зарлагын өсөлтийг царцаасан байна. 2016 оноос Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. (ОУВС).

Эдийн засгийн хүндрэлийн үед хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээнээс үзэхэд Засгийн газраас мөчлөг дагасан төсвийн бодлого баримталсан нь хөдөлмөрийн салбарын зарлага 2015-2018 онд буурах үндсэн шалтгаан болсон байна.

Хөдөлмөрийн салбарын зарлагын нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2010-2014 онд 2.0-2.6 хувь байсан бол 2015-2020 онд 1.2-1.9 хувь болж буурсан байна.

Зураг 5. Хөдөлмөрийн салбарын зарлагын нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь




Эх сурвалж: СЯ, УСХ

Хэдий нэгдсэн төсвийн нийт зарлага нэмэгдсэн ч хөдөлмөрийн салбарын зарлагын нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2015-2019 онд буурах чиг хандлагатай байгаа нь Зураг 5-аас тодорхой харагдаж байна.

3.4. Хөдөлмөрийн салбарын зарлагын бүтэц

Хөдөлмөрийн салбарын зарлагын бүтцийг 2010-2021 онд жил үзэхэд урсгал зарлага дийлэнх хэсгийг эзэлж байна. Эргэж төлөгдөх зээл, хөрөнгө оруулалтын зардал харьцангуй бага хувийг эзэлж байна.

Зураг 6. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц, 2010-2021 (тэрбум төгрөг)



Эх сурвалж: СЯ

2010-2021 онд хөдөлмөрийн салбарын төсөвт урсгал зардал 87 хувь, эргэж төлөгдөх зээл 8 хувь, хөрөнгө оруулалт 5 хувийг тус тус эзэлж байна (Зураг 6).

Зураг 7. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц³(эдийн засгийн ангиллаар)




Эх сурвалж: СЯ

2.1-д тайлбарласанчлан хөдөлмөрийн салбарын төсвийн зарлагыг хөтөлбөрийн ангиллаар харуулахад хүндрэлтэй байлаа. Иймд хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, хөрөнгө оруулалт гэж 3 ангилан зарлагын чиг хандлагыг дэлгэрэнгүй авч үзлээ. Мэргэжлийн боловсролтой холбоотой зарлага нийт хөдөлмөр эрхлэлтийн салбарын зардалд голлох хувь буюу 50 хувь, ХЭДС 32 хувийг эзэлж байгаа бол хөрөнгө оруулалт болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага хэрэгжүүлэлтийн зарлага харьцангуй бага хувийг эзэлж байна.


³ 2010-2021 оны хөдөлмөрийн салбарын зарлагын дундажаар тооцов

Зураг 8. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын бүтэц



Эх сурвалж: СЯ

Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлага, тусгай ангиллаар, тэрбум төгрөг



Эх сурвалж: СЯ

2011-2018 онд хөдөлмөрийн салбарын нийт зарлагад хөдөлмөр эрхлэлтийн зориулалттай зарлага мэргэжлийн боловсролд зориулсан зарлагаас өндөр байсан бол 2010 он болон 2020-2021 онд мэргэжлийн боловсролд зориулсан төсвийн зарлага хөдөлмөр эрхлэлтэд зориулсан төсвийн зарлагаас өндөр батлагдсан байна. Энэ нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид олгох сарын тэтгэлгийн хэмжээг 2019 онд 100.0 мянган төгрөг, 2020 онд 200.0 мянган төгрөг болгосонтой холбоотой байна.


3.4.1. Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулж улсын төсвөөс олгож буй санхүүжилт нь ХЭДС-аас санхүүжүүлж буй арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага, хэрэгжилт, судалгаа, хөдөлмөрийн аюулгүй байдалд зориулж буй захиргааны шинжтэй зардлаас бүрдэж байна.

2010-2021 оны хооронд ХЭДС-ийн зарлагын жилийн дундаж өсөлт 26 хувь буюу харьцангуй өндөр өсөлттэй, зарлагын өөрчлөлтийн хувь өндөр хэлбэлзэлтэй байна(Зураг 10). ХЭДС-гийн зарцуулалтын **стандарт хазайлт 56 хувь** буюу хэлбэлзэл өндөр байгааг харуулж байна.

Тухайлбал, ХЭДС-гийн эх үүсвэр 2011 онд 161 хувь, 2013 онд 63 хувь, 2017 онд 52 хувь, 2019-2021 онд 10-60 хувиар тус тус өссөн бол 2012 онд 5 хувь, 2014-2016 онд 18-35 хувиар буурсан. Ерөнхийдөө тус сангийн зарлагын өөрчлөлт нь 2010-2021 онд буурах чиг хандлагатай байна. Хэлбэлзэл өндөр гарахад 2011 оны хэт өндөр өсөлт нөлөөлсөн байх талтай юм.

Зураг 10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан




Эх сурвалж: СЯ

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага, хэрэгжилтийг ХНХЯ, ХХҮЕГ, орон нутаг дах ХХҮГ болон бусад байгууллага зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр байгууллага

нь халамжийн үйл ажиллагааны чиг үүргийг давхар хэрэгжүүлэн ажилладаг. Энэ нь хөдөлмөрийн салбарын зарлагыг тодорхойлоход хүндрэл учруулж байлаа. Холбогдох зардал нь Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага, хэрэгжилт хөтөлбөрт хамаарахгүй харин Нийгмийн халамж хөтөлбөрт хамаарч байна. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага, хэрэгжилтийн 2010-2021 оны хоорондын зарцуулалтын стандарт хазайлт **93 хувь буюу** хэлбэлзэл их байгааг харуулж байна. Хэлбэлзэл өндөр гарахад 2011 оны хэт өндөр өсөлт нөлөөлж байгааг Зураг 11 тодорхой харуулж байна. Мөн 2013-2019 онд уг арга хэмжээнд зориулсан зарлага тогтворгүй, тогтмол хэлбэлзэлтэй байна.

Зураг 11. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хэрэгжилт, удирдлага болон бусад арга хэмжээ




Эх сурвалж: СЯ

3.4.2. Мэргэжлийн боловсрол, сургалт

“Мэргэжлийн боловсрол” хөтөлбөр нь улсын төсвийн санхүүжилттэй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төсөв, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн төсөв гэсэн хоёр эх үүсвэрээс санхүүжиж байна.

Мэргэжлийн боловсролын байгууллагуудын төсөв харьцангуй тогтвортой байна. 2010-2021 оны хооронд зөвхөн 2015 онд эдийн засгийн хүндрэлтэй үед 24 хувь буурсныг эс тооцвол харьцангуй тогтвортой байна. 2016, 2017 онд 1 хувь, бусад онд 4-21 хувь өссөн байна. Ерөнхийдөө 2011-2021 оны хооронд мэргэжлийн боловсролын байгууллагуудын төсвийн зарлага ялимгүй өсөлттэй байна.

Зураг 12. Мэргэжлийн боловсролын байгууллагуудын төсвийн зарлагын чиг хандлага




Эх сурвалж: СЯ

МБСДС -ийн зарлагын жилийн дундаж өсөлт нь 2011-2021 оны хооронд 50 хувь буюу өндөр өсөлттэй, зарлагын өөрчлөлтийн хувь өндөр хэлбэлзэлтэй байгаа нь Зураг 13-аас өөс харагдаж байна. МБСДС-ийн 2011-2021 оны хоорондох зарцуулалтын **стандарт хазайлт нь 109 хувьтай** байгаа нь хэлбэлзэл маш өндөр байгааг харуулж байна.

МБСДС нь 2011-2015 оны хооронд харьцангуй тогтвортой өсөлттэй байсан боловч 2016-2018 оны хооронд 2-48 хувиар огцом буурсан байна. Харин 2019 онд зарлагыг өмнөх оноос 2 дахин, 2020 онд 1.5 дахин, 2021 онд 31 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна. 2011-2021 оны зарлагын ерөнхий чиг хандлага нь маш өндөр өсөлттэй байна.

Зураг 13. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарлагын чиг хандлага




Эх сурвалж: СЯ

3.4.3. Хөрөнгө оруулалт

Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалтын зарлага, түүний өөрчлөлт нь 2010-2021 оны хооронд буурах хандлагатай, ихээхэн хэлбэлзэлтэй буюу тогтворгүй байсан байна.

Хөрөнгө оруулалт 2011 онд өмнөх оноос 8.6 дахин, 2012 онд өмнөх оноос 4.8 дахин тус тус өссөн байна. Хэдийгээр 2013 онд хөрөнгө оруулалт 51 хувиар буурсан ч 2014 онд 1.8 дахин нэмэгдсэн байна. 2012-2016 оны хооронд Засгийн газрын бүтцэд хөдөлмөрийн салбарыг хариуцсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүрэгтэй бие даасан Хөдөлмөрийн яам байгуулсан бөгөөд энэ үед салбарын хөрөнгө оруулалт харьцангуй өндөр байсныг Зураг 14 харуулж байна. 2016 оноос Хөдөлмөрийн яам татан буугдан нийгмийн хамгааллын чиг үүрэгтэй нэгдсэний дараа хөдөлмөрийн салбарт олгох хөрөнгө оруулалт эрс буурсан байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалт Хөдөлмөрийн яамны эрхлэх асуудалд харьяалж байсантай зарим талаар холбоотой байна.

Зураг 14. Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалт




Эх сурвалж: СЯ

Хөрөнгө оруулалтыг хөтөлбөрт суурилсан төсөвлөлт буюу хөтөлбөрийн зарлагын бүрэлдэхүүн хэсэгт оруулаагүй байдал ажиглагдаж байна. Тухайлбал, төсвийн төсөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн шатанд хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, төсөвтэй уялдуулаагүй байна.

Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалтыг зориулалтаар нь авч үзвэл мэргэжлийн боловсрол, сургалтын хөрөнгө оруулалт дийлэнх хувийг эзэлж байна (Зураг 15) . Мэргэжлийн боловсрол, сургалтын хөрөнгө оруулалтын дийлэнхийг мэргэжлийн сургалтын байгууллагын барилга барихад зориулан хуваарилсан бөгөөд тоног төхөөрөмжид маш бага хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн хөрөнгө оруулалт нь харьцангуй бага байна. Орон нутаг дах Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн барилга, их засварын зардал нь хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн хөрөнгө оруулалтын дийлэнхийг эзэлж байна.


Зураг 15. Хөрөнгө оруулалт, зориулалтаар (сая төгрөг)



Эх сурвалж: СЯ

Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл барилгын зардал дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд их засвар, тоног төхөөрөмж харьцангуй бага хувийг эзэлж байна.

Зураг 16. Хөрөнгө оруулалт, эдийн засгийн ангиллаар (сая төгрөг)



Эх сурвалж: СЯ

Зөвхөн төрийн захиргааны байгууллагын барилга, байгууламжаар хязгаарлагдаж байгаа тул хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд шууд нөлөөлөл багатай байна. Харин мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих чиглэлээр барих барилга, их засвар, сургалтын нөхцөлийг сайжруулах, дадлага сургуулилт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж нь хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг болж байна.

Хөдөлмөрийн салбарын өөрийн онцлогоос хамаараад ХНХЯ-д олгож буй хөрөнгө оруулалт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд төдийлөн

ач холбогдол багатай байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шууд дэмжлэг үзүүлэхтэй ямар нэг хамаарал байхгүйтэй холбоотой байна.


4. Хөдөлмөрийн салбарын төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ

Хөдөлмөрийн салбарын 2011-2019 оны батлагдсан төсөв болон гүйцэтгэлийн хоорондын зөрүүг батлагдсан төсөвт харьцуулж төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү хувь хэмжээг тодорхойллоо. Тухайн хугацаанд хөдөлмөрийн салбарын нийт зарлага, урсгал зарлага, хөрөнгийн зарлагын гүйцэтгэлийн биелэлтийн хувь хэмжээ батлагдсан төсвөөс ихээхэн доогуур байна. Тухайлбал, **Зураг 17-д үзүүлснээр** нийт зарлага нь 6 -26 хувь, урсгал зарлага нь 6 -27 хувь, хөрөнгийн зарлага 3 -37 хувь доогуур буюу батлагдсан төсвөөс дутуу санхүүжилт хийгдсэн байна.

2011-2019 оны хооронд нэг жилд ногдох төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүний дундаж хувь хэмжээ нь урсгал зарлагын хувьд **-14** хувь, стандарт хазайлт -6 хувь, хөрөнгийн зарлагын хувьд **-21** хувь, стандарт хазайлт 24 хувь, нийт зарлагын хувьд **-15** хувь, стандарт хазайлт 6 хувь байна. Энэ нь хөрөнгийн зарлагын гүйцэтгэл болон төсвийн төлөвлөлтийн хоорондын зөрүү нь урсгал зарлагын зөрүүнээс илүү их хэмжээний хэлбэлзэлтэй байгааг харуулж байна. Төсвийн Зарлага болон Санхүүгийн хариуцлагын үнэлгээний гарын авлагад төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү хувь 85-115 хувийн хооронд байвал А, В, С, D гэсэн онооноос С буюу доогуур үнэлгээг өгөхөөр тусгасан байна (PEFA, 2019). Тус үнэлгээгээр хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлд С буюу бага үнэлгээг өгөхөөр байна.

Зөвхөн хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү 15 хувийг бусад 24 ТЕЗ нарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулбал дундаж түвшинд байна (Заяадэлгэр, Эрдэмчимэг, 2020).

Зураг 17. Хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү хувь хэмжээ



Батлагдсан төсөв болон гүйцэтгэлийн хоорондын зөрүү өндөр гарсны үндсэн шалтгаан, тайлбар тодорхойгүй байна. **Хөдөлмөрийн салбарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээнээс төсвийг хэмнэлттэй, үр ашигтай удирдсан эсэх, төсөв анх батлагдахдаа бодит хэрэгцээнээс илүү төсөвлөсөн эсэх, эсвэл эдийн засгийн хүндрэлийн улмаас санхүүжилтийг дутуу олгосон эсэх, төсвийн санхүүжилтийг дутуу олгосон шалтгааныг тогтоох, дүгнэх боломжгүй байна.** Цаашид, хөдөлмөрийн салбарын төсвийн гүйцэтгэл батлагдсан төсвөөс доогуур байгааг нарийвчлан судлах, дүн шинжилгээ хийх, шалтгааныг тодорхойлох шаардлагатай юм.

Хөдөлмөрийн салбарын төсвийн гүйцэтгэл нь батлагдсан төсвөөс жил бүр ихээхэн хэмжээгээр доогуур байгаа ч хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд тухай бүр ямар нэг өөрчлөлт, тодотгол хийж байгаагүй байна. **Төсвийн гүйцэтгэл болон батлагдсан төсвийн зөрүүг хөдөлмөрийн салбарын хөтөлбөрийн хүрсэн үр дүн, шалгуур үзүүлэлттэй уялдуулж судлах шаардлагатай байна.**


Цаашид төсвийн хэмнэлт, хэтрэлтийн талаар жил бүр дүн шинжилгээ хийх, өмнөх оны хэмнэлт, хэтрэлттэй харьцуулах, дунд болон урт хугацааны төсвийн судалгаа хийх, учир шалтгааныг тодорхой судлах шаардлагатай байна.

5. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын үр дүнгийн шинжилгээ

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн зарлага төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах зориулалтаар олгож буй санхүүжилт юм. Уг санхүүжилтийг “орц”, жил бүрийн Төсвийн тухай хуулийн Хавсралт 1 -т заасан хөдөлмөр эрхлэлтийн салбарын үр дүнгийн үзүүлэлтийг “гарц”- гэж тооцон тус салбарын зарлагын үр дүнг тодорхойлохыг зорилоо.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын нийт зарлага болон ажилгүйдлийн түвшин хоорондын хамаарлын коэффициент нь – **0.56** буюу урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн салбарт олгож буй төсвийн санхүүжилт нэмэгдэхэд ажилгүйдлийн түвшин буурсан байна. Энэ нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийн салбарт олгож буй санхүүжилт нь харьцангуй **үр дүнтэй** байна гэж дүгнэж болохоор байна.


Зураг 18. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон ажилгүйдлийн түвшин хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар)



Эх сурвалж: СЯ, ҮСХ

Хөдөлмөрийн салбарын зарлага болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин хоорондын хамаарлын коэффициент нь – **0.06** буюу бага хэмжээгээр урвуу хамааралтай байна.


Зураг 19. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар)



Эх сурвалж: СЯ, ҮСХ

Төсвийн хуулийн Хавсралт 1-д Хөдөлмөр эрхлэлт хөтөлбөрийн үндсэн үзүүлэлт “Шинээр бий болсон ажлын байр” батлагдсан. Энэ үзүүлэлт болон төсөв хоорондын хамаарлын коэффициент нь 0.46 буюу эерэг хамааралтай байна.


Зураг 20. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын төсвийн нийт зардал болон шинээр бий болсон ажлын байрны тоо хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хувиар)



Хөдөлмөр эрхлэлтийн салбарын санхүүжилтээр ХЭДС-аас санхүүжүүлсэн хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон ажлын байрны тоо, ажилтай болсон МТБСБ-ын төгсөгчдийн тоог ажилгүй хүний тоотой харьцуулан судаллаа.

Шинээр бий болсон ажлын байрны тоо, ажилтай болсон МТБСБ-ийн төгсөгчдийн нийт тооны ажилгүй хүний тоонд эзлэх хувь 2013 онд 77.2 хувь буюу маш өндөр хувийг эзэлж байсан байна. Харин 2013-2017 оны хооронд шинээр бий болсон ажлын байрны тоо, ажилтай болсон МТБСБ-ийн төгсөгчдийн ажилгүй хүний тоонд эзлэх хувь хэмжээ нь тогтмол буурсаар байсан бөгөөд 2017 онд 30.9 хувь буюу маш бага хувийг эзэлж байжээ. 2018 оноос эхлэн шинээр бий болсон ажлын байр болон ажилтай болсон МТБСБ-ын төгсөгчдийн ажилгүй хүмүүсийн тоонд эзлэх хувь хэмжээ нь эргээд бага зэрэг нэмэгдэж 2020 онд 45.1 хувь болон нэмэгдсэн байна. Энэхүү дүн шинжилгээнээс үзэхэд шинээр бий болсон ажлын байр, ажлын байртай болсон МТБСБ-ын төгсөгчдийн хувь хэмжээ нь **буурах чиг хандлагатай** буюу **үр дүнгийн үзүүлэлт нь буурсан** байна. Өөрөөр хэлбэл, шинээр бий болсон ажлын байрны тоо хэмжээ буурах, мөн тус ажлын байр нь урт хугацаанд тогтвортой хадгалагдаж чадахгүй байна.

Зураг 21. Шинээр бий болсон ажлын байрны тоо болон ажлын байртай болсон МТБСБ-ийн төгсөгчийн тооны ажилгүй хүний тоонд эзлэх хувь



Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ, ҮСХ

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

Хөдөлмөрийн салбарт өнөөгийн байдлаар хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг зохицуулахад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих тухай хууль зэрэг хуулиуд үйлчилж байна.

ТХЗ-2030, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д туссан зорилго, зорилгод нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016 оны 304 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан, хэрэгжүүлж байна.

6.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд ХЭДС-ын орлого нь улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллаас төлөх төлбөр, гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл, хандив, тусламж, гадаадын болон дотоодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас олгосон хандив, тусламж, уг сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгөөс тус тус бүрдэхээр заасан байна.

ХЭДС-ийн орлогын дийлэнх хэсгийг гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр эзэлж байна. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.2-т “Ажлын байрны төлбөрийн хэмжээ нь 1 сард гадаадын иргэн бүрд Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна” гэж заасны дагуу төлбөр ногдуулан орлогыг төвлөрүүлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтад “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэсэн шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагууд уг хуулийн 111.2- дэх заалт дах “... хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” гэсний дагуу холбогдох төлбөрийг ХЭДС-д төлдөг. Төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолын дагуу Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт тухайн байгууллагын ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар тус тус тооцон төлбөр авч байна.

ХЭДС-ийн 2016-2020 оны орлогын бүрэлдэхүүн хэсгийг авч үзэхэд орлогын дийлэнх хэсгийг гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого эзэлж байна. 2018 оноос эхлэн ХЭДС-ийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг төсөвт тусгадаг болсонтой тул санхүүжилтийн хэмжээ огцом нэмэгдсэн байна. Тухайлбал, 2016-2020 оны дунджаар тооцоход гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого 27.3 хувь, өмнөх оны үлдэгдэл 44.9 хувь, улсын төсвийн санхүүжилт 8.4 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 2.2 хувийг тус тус эзэлж байгааг Хүснэгт .. -т харуулав. **Гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн он дамжсан хуримтлал нь уг сангийн гол эх үүсвэр болж байна.**

Хүснэгт 7. ХЭДС-ийн орлогын бүтэц, сая төгрөгөөр

№	Орлогын төрөл	2016	2017	2018	2019	2020	5 жилийн дундаж	Эзлэх хувь
1	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого	30,812.8	29,704.5	38,615.5	54,348.7	26,266.4	35,949.6	27.3%
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс орох орлого	393.2	1,012.2	1,128.0	3,683.0	8,325.1	2,908.3	2.2%
3	Улсын төсөв			3,850.0	9,100.0	20,330.2	11,093.4	8.4%
4	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж					7,415.0	7,415.0	5.6%
5	Жижиг зээлийн эргэн төлөлт		17,000.0	4,350.0			10,675.0	8.1%
6	Жижиг зээлийн хүү, алданги		187.3	156.6	67.2	256.9	167.0	0.1%
7	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	1,570.4	3,691.3	7,275.2			4,179.0	3.2%
8	Бусад	264.1	12.1	167.4	29.6	14.1	97.5	0.1%
9	Өмнөх оны үлдэгдэл			39,244.0	44,113.3	93,550.8	58,969.4	44.9%
	Нийт орлого	33,040.5	51,607.5	94,786.7	111,341.8	156,158.6	131,454.1	100.0%

Эх сурвалж: ХХҮЕГ

Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон гадаад иргэдийн тооноос хамаарч байна. Доорх зурагт үзүүлснээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2016 оны сарын 192.0 төгрөгөөс 2017 онд 240.0

мянган төгрөг болж, 44.0 мянган төгрөгөөр нэмэгдэхэд 2016 оны орлогын хэмжээ 30.8 тэрбум төгрөгөөс 2017 онд 29.7 тэрбум төгрөг болж буурсан байна. Энэ нь гадаад иргэдийн тоо 2017 онд 10.5 мянга болж, өмнөх оноос 0.7 мянган хүнээр буурсантай холбоотой байна.

2020 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь өмнөх жилүүдээс өндөр буюу 420.0 мянган төгрөг байгаа ч гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого 2020 онд 26.3 тэрбум төгрөг болж өмнөх онуудаас огцом буурсан нь КОВИД-19 цар тахлын улмаас гадаад ажилчдын тоо 2.8 мянга болсонтой холбоотой байна.

Зураг 22. Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого, гадаад иргэдийн тоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрүүд, тэдгээрийн зарлагын үр ашиг, үр дүнгийн шинжилгээ

Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтад туссан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ (ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах), 6.2 дах заалтад туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ (Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих)-г тус тус хэрэгжүүлж байна. Эдгээр үйлчилгээг ХНХЯ, ХХҮЕГ, орон нутаг дах ХХҮГболон бусад байгууллагууд үзүүлдэг бөгөөд ХЭДС-аас санхүүжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7 дах заалтын дагуу Засгийн газар болон ХЭҮЗ-өөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг ХЭДС-аас санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр заасан. Энэ хүрээнд ХЭҮЗ-ийн шийдвэрээр ХЭДС-гийн

санхүүжилттэй зургаан зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр гэсэн хөтөлбөр хөдөлмөрийн зах зээлийг дэмжих, нийгмийн тодорхой бүлгийн ажлын байрыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7 дах заалт, Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын дагуу ХЭДС-аас жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хөдөлмөр эрхлэх, иргэний ганцаараа болон бусадтай хамтран нөхөрлөл, хоршоо байгуулах, эрхлэхэд зориулан олгож байна.

ХЭДС- гаас санхүүжүүлж буй нийтлэг үйлчилгээ болон 6 төрлийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийгмийн тодорхой бүлгүүдийн онцлогт тохируулсан дэмжлэг, үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучууд, ахмад настан, хөдөө орон нутгийн малчин иргэд, эмзэг бүлгийн иргэд, ажилгүй иргэн, ажил хайж байгаа иргэн, бичил бизнес эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэн, шинээр ажлын байр нэмэгдүүлэх, орлого олох, орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой иргэн зэрэг зайлшгүй дэмжлэг, тусламж шаардлагатай хэсгийг хамарч байна. **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл нь нийгмийн тэгш байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхтэй уялдаж байна.**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, жишиг зээл зэрэг арга хэмжээнд зарцуулж буй төсвийн зардлыг гарцын болон үр дүнгийн үзүүлэлтүүдтэй харьцуулах аргаар тухайн хөтөлбөр, төслийн үр ашиг, үр дүнг тодорхойлохыг хичээлээ. Зөвхөн тоон үзүүлэлт дээр үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн салбарын үр дүн, үр ашгийг тооцож гаргах нь учир дутагдалтай байна. Тухайлбал, төсвийн зарлагын хэмжээ нэмэгдэхэд тухайн хөтөлбөрт хамрагдах хүний тоо, бий болсон ажлын байрны тоо нэмэгдэж байгаа ч тухайн хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжсэн гэж шууд дүгнэх боломжгүй юм. Мөн тухайн хөтөлбөрт хамрагдсан нэг хүнд ногдох зардлын хэмжээгээр болон нэг ажлын байр бий болгох зардлын өсөлт, бууралтаар үр ашгийг хэмжих нь зарим тохиолдолд учир дутагдалтай байгаа нь ажиглагдлаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүн, үр ашгийг тооцоход ашиглаж байгаа статистик мэдээлэл, өгөгдлийн үнэн зөв, чанарыг харгалзан үзэх шаардлага тавигдаж байна. Тухайлбал, бий болсон ажлын байр гэдгийг хэрхэн тодорхойлох, эдгээр бий болсон ажлын байр нь ямар хугацаанд тогтвортой оршин байгаа эсэх, тухайн ажлын байранд олгох цалингийн хэмжээ эсвэл олох орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, дундаж цалингаас хэр хэмжээгээр өндөр байгаа зэргийг илүү нарийвчилсан, найдвартай мэдээлэлд үндэслэн үнэн зөв гарах шаардлагатай байна.

Одоогоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан хүмүүс болон нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй, үр ашигтай дэмжлэг, үйлчилгээг батлагдсан төсвийн хэмжээ болон мөрдөгдөж буй санхүүгийн дэмжлэг, зээлийн хэмжээ, нийтлэг үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдаж буй тариф, норм, норматив хэмжээнд хангалттай авч чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийх боломж хомс байна.

6.2.1. ХЭДС-гийн нийт зарлагад хийсэн шинжилгээ

ХЭДС-гийн нийт зарлагын дүнг орц, тухайн жилд ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бий болсон ажлын байрны тоог гарц гэж авч үзэхэд хоорондын хамаарал 0.7 буюу эерэг хамааралтай байна. Төсвийн зарлагын хэмжээ буурахад шинээр бий болсон ажлын байрны тоо буурч, зарлагын хэмжээ нэмэгдэхэд ажлын байрны тоо нэмэгдэх чиг хандлага ажиглагдаж байна.

Зураг 23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлага болон шинээр бий болсон ажлын байрны хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, хүний тоогоор)




Эх сурвалж: СЯ, ХХҮЕГ

ХЭДС-аас санхүүжиж буй зургаан хөтөлбөрийн төсвийн үр дүн, үр ашгийн тооцоог нийт хөтөлбөр болон хөтөлбөр тус бүрт харьцуулан шинжилгээг хийлээ. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 2016-2020 онд нийт 23.2-53.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 19.1-38.3 мянган ажлын байрыг бий болгосон байна. Зураг 23-т харуулсанчлан хөтөлбөрүүдийн нийт зарлага 2016-2017 оны хооронд өсөлттэй, 2017-2020 онд бууралттай байна. Бий болсон ажлын байрны тоо 2017 онд өсөлттэй, 2018-2020 онд бууралттай байна. Ялангуяа тодорхой шалтгаанаар 2020 онд зарлага болон бий болсон ажлын байр огцом буурсан.

2016-2020 онд нийт зарлага дунджаар 4 хувь буурсан бол шинээр бий болсон ажлын байрны тоо 8 хувь буурсан байна. Зарлагын өсөлтийн хурднаас шинээр бий болсон ажлын байрны өсөлтийн хурд бага байсан байна. Эндээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан зарцуулсан хөрөнгийн **үр ашиг хангалтгүй** гэж дүгнэж болохоор байна. Мөн хугацаанд хөтөлбөрүүдийн санхүүжилт, бий болсон ажлын байрны хоорондын хамаарлын коэффициент **0.7** буюу хоорондоо хүчтэй хамааралтай гарсан байна. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрүүдийн зарлага нэмэгдэхэд ажлын байрны тоо өсөх чиг хандлагатай гарч байна. Гэвч зарлагын өсөлтийн хурд нь ажлын байрны өсөлтийн хурднаас өндөр байна.

ХЭДС-аас хэрэгжүүлж буй 6 хөтөлбөрийн нийт зарлагыг нийт бий болсон ажлын байранд харьцуулж нэг ажлын байрыг бий болгоход зарцуулж буй хөрөнгийг тодорхойллоо. 2016-2020 онд нэг ажлын байрыг бий болгох зардал 468.9-935.6 мянган төгрөг буюу өсөх хандлагатай байна. Харин зөвхөн 2018 онд нэг ажлын байр бий болгоход гарсан зардал 663.6 мянган төгрөг болж өмнөх оноос 11 хувиар буурсан байна. **Шинээр нэг ажлын байрыг бий болгоход гарсан зардлыг хувийн хэвилийн зардалтай харьцуулан тооцох боломжгүй байна.**


Зураг 24. ХЭДС-ийн 6 хөтөлбөрүүдийн нийт зардал (сая төгрөг) болон бий болсон ажлын байр



Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ

Зураг 25 -аас харахад 2017, 2019, 2020 онд хөтөлбөрүүдийн санхүүжилтийн өөрчлөлтийн хувь хэмжээ нь бий болсон ажлын байрны өөрчлөлтийн хувь хэмжээнээс өндөр байсан бөгөөд харин 2018 онд бий болсон ажлын байрны өсөлтийн хувь хөтөлбөрүүдийн зардлын өсөлтийн хувиас өндөр байсан байна. 2016-2020 оны хооронд хөтөлбөрийн зардлын өсөлт нь бий болгосон ажлын байрны тооны өсөлтөөс илүү хурдтай байсан байна. Тухайлбал, 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн зарлага өмнөх оноос 58 хувиар өссөн бол бий болсон ажлын байрны тоо 2 хувиар буурсан, 2018 онд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн зарлага өмнөх оноос 8 хувиар өссөн бол бий болсон ажлын байрны тоо 21 хувиар өссөн, 2019 онд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн зарлага 18 хувиар өссөн бол бий болсон ажлын байрны тоо 7 хувиар буурсан, 2020 онд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн зарлага 44 хувь, ажлын байрны тоо 50 хувиар буурсан байна.

Зураг 25. Хөтөлбөрүүдийн санхүүжилтийн өөрчлөлт болон бий болсон ажлын байрны өөрчлөлт (өөрчлөлтийн хувиар)



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2.2. ХЭДС-гийн санхүүжилттэй хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт иргэдийн тоонд шинээр бий болсон ажлын байрны тооны эзлэх хувь хэмжээ, үр дүн

ХЭДС-гийн санхүүжилттэй 6 хөтөлбөрт хамрагдан ажилтай болсон иргэдийн тоог нийт хамрагдсан иргэдийн тоонд харьцуулан хөтөлбөрийн ерөнхий үр дүнг тооцож үзлээ. 2016-2020 онд ажлын байртай болсон иргэд тус хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдэд эзлэх хувь 48-66 хувь, 5 жилийн дундаж 58 хувьтай байна.

Хүснэгтэд үзүүлснээр 2016-2020 оны хооронд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан иргэдийн ажлын байртай болсон хувь маш өндөр буюу 96-102 хувьтай байна.

2016-2020 онд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж ажлын байртай болсон иргэдийн нийт хамрагдсан хүмүүст эзлэх хувь 55-81 хувь, 5 жилийн дундаж хувь 66 хувь, стандарт хазайлт 11 хувь байна. Хөтөлбөрийн үр дүнг дунд хэрэгжсэн гэж дүгнэж болохоор байна.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-т 2016-2020 онд хамрагдсан иргэдээс ажлын байртай болсон иргэдийн эзлэх хувь нь буурсан хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, тус хөтөлбөрүүдийн үр дүн хангалтгүй гэж үзэж болохоор байна.

Тухайлбал, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-т 2016 онд хамрагдсан хүмүүсийн 57 хувь нь ажлын байртай болж байсан бол уг үзүүлэлт

2017 онд 22 хувь, 2018 онд 27 хувь, 2019 онд 13 хувь, 2020 онд 10 хувь болж тасралтгүй буурсан байна. Уг хөтөлбөрт 2016-2020 оны хоорондох 5 жилийн хугацаанд хамрагдсан хүмүүсээс ажлын байртай болсон хүмүүсийн дундаж хувь хэмжээ 26 хувь, стандарт хазайлт 19 хувьтай байна.

Хүснэгт 8. Хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт хүмүүсийн тоонд ажлын байртай болсон хүмүүсийн эзлэх хувь

№	Хөтөлбөрийн нэр						5 5	Стандарт хазайлт
		2016	2017	2018	2019	2020	жилийн дундаж	
1	Хөдөлмөрт бэлтгэх, ХЭ-н ур чадвар олгох хөтөлбөр	57%	22%	27%	13%	10%	26%	0.19
2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	71%	55%	67%	55%	81%	66%	0.11
3	Залуучуудын ХЭ, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	59%	15%	14%	13%	8%	22%	0.21
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	100%	100%	100%	100%	100%	100%	-
5	ХБИ-н ажлын байрыг дэмжих хөтөлбөр	45%	25%	24%	21%	38%	31%	0.10
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	96%	102%	102%	96%	102%	99%	0.03
	Нийт 6 хөтөлбөр	66%	50%	59%	48%	66%	58%	0.09

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 2016 онд хамрагдсан хүмүүсийн 45 хувь нь ажлын байртай болж байсан бол уг үзүүлэлт 2017 онд 25 хувь, 2018 онд 24 хувь, 2019 онд 21 хувь болж тасралтгүй буурсан, харин 2020 онд 38 хувь болж өссөн байна. Уг хөтөлбөрт 2016-2020 оны хоорондох 5 жилийн хугацаанд хамрагдсан хүмүүсээс ажлын байртай болсон хүмүүсийн дундаж хувь хэмжээ 31 хувь, стандарт хазайлт нь 10 хувьтай байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-т 2016 онд хамрагдсан хүмүүсийн 59 хувь нь ажлын байртай болж байсан бол 2017 онд 15 хувь, 2018 онд 14 хувь, 2019 онд 13 хувь, 2020 онд 8 хувь болж тасралтгүй буурсан байна. Уг хөтөлбөрт 2016-2020 оны хоорондох 5 жилийн хугацаанд хамрагдсан хүмүүсээс ажлын байртай болсон хүмүүсийн дундаж хувь хэмжээ 22 хувь, стандарт хазайлт 21 хувьтай байна.

ХЭДС-гаас санхүүжиж буй 6 хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байрны тоог нийт хамрагдсан хүмүүсийн тоонд харьцуулсан хувиар хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож үзэхэд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр” **харьцангуй үр дүн сайн**, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр” дунд зэргийн үр дүнтэй, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр” нь үр дүн хангалтгүй байна.

6.2.3. Хөтөлбөрүүдийн зарлагын үр ашгийн тооцоо

Хөтөлбөрүүдийн санхүүжилтийн үр ашгийг хөтөлбөр бүрээр нь тооцож үзлээ. Хөтөлбөр тус бүрээр нэг ажлын байрыг бий болгоход зарцуулсан хөрөнгө харилцан адилгүй байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”- нь бусад хөтөлбөрүүдээс өндөр зардалтай байна.


6.2.3.1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд сургах, дадлагажуулахад чиглэгдэж байна.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн зарлага 2016 онд 1,481.7 сая төгрөг байсан бол 2017 онд 1,137.7 сая төгрөг, 2018 онд 1,012.5 сая төгрөг, 2019 онд 886.6 сая төгрөг, 2020 онд 200.1 сая төгрөг болж тогтмол буурсан байна.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн хүрээнд 2016-2020 онд нэг ажлын байрыг бий болгоход жилд 454.0-942.2 мянган төгрөг зарцуулсан нь бусад хөтөлбөртэй харьцуулахад бага байна. Нэг ажлын байрыг бий болгоход олгож буй санхүүжилт нь 2016 онд 454.0 мянган төгрөг байсан бол 2019 онд 942.2 мянган төгрөг, 2020 онд 755.0 мянган төгрөг болж өссөн байна. Харин бий болсон ажлын байрны тоо 2016-2020 онд 3264-өөс 265 болж тасралтгүй буурсан байна. Эндээс үзэхэд уг хөтөлбөрийн үр ашгийг хангалтгүй гэж дүгнэх боломжтой байна.

Зураг 26. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2.3.2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр


“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад

дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн зарлага 2017 он болон 2019 онд өсөж, 2018 он болон 2020 онд буурсан буюу байнгын хэлбэлзэлтэй байна (Зураг 27).

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2016 онд нэг ажлын байрыг бий болгох зардал 660.3 мянган төгрөг байсан бол 2020 онд 649.3 мянган төгрөг болж ялимгүй буурсан байна. Харин 2017-2019 онд нэг ажлын байр бий болгох зардал 432.2-576.1 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан байна. Өөрөөр хэлбэл, нэг ажлын байрыг бий болгох зардал нь буурах хандлагатай байна. Харин бий болсон ажлын байрны тоо 2016 онд 8319 байсан бол 2017 онд 20164, 2018 онд 25947, 2019 онд 24926 болж огцом нэмэгдсэн байна. Харин цар тахалтай холбоотойгоор 2020 онд бий болсон ажлын байрны тоо 15032 болж огцом буурсан байна. Ерөнхийдөө, уг хөтөлбөрийн **үр ашиг боломжийн** түвшинд байна гэж дүгнэх боломжтой байна.

Зураг 27. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2.3.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр


“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь 15-34 насны залуучууд, ялангуяа ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд, түүнчлэн их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид болон төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах, аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхэд туслах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэж байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн зарлага 2017-2019 онд 1,715.7-5,193.5 сая төгрөг буюу тогтмол өсөлттэй байна. Харин цар тахлаас үүдэн 2020 онд 1,158.8 сая төгрөг болж огцом буурсан байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 онд нэг ажлын байрыг бий болгох зардал 2,723.3 мянган төгрөг байсан бол 2020 онд 5,736.5 мянган төгрөг болж тасралтгүй өссөн байна. Өөрөөр хэлбэл, нэг ажлын байрыг бий болгох зардал өсөх хандлагатай байна.

Бий болсон ажлын байрны тоо 2017-2019 онд 630-1029 болж тогтмол өссөн ч 2020 онд 202 болж огцом буурчээ. Уг хөтөлбөр нь залуусын гарааны бизнесийг дэмжихэд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд бусад хөтөлбөртэй харьцуулбал харьцангуй өндөр зардал шаардагддаг байна.

Зураг 28. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2.3.4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгоход чиглэж байна.


“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн зарлага 2016-2018 онд 4,292.3-5,702.7 сая төгрөг буюу тогтмол өссөн байна. 2019 онд 5,505.8 сая төгрөг болж ялимгүй буурсан бөгөөд цар тахлаас үүдэн 2020 онд 2,374.2 сая төгрөг болж огцом буурсан байна.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2016 онд нэг ажлын байрыг бий болгох зардал 1,064.6 мянган төгрөг байсан бол 2017 онд 925.0 мянган төгрөг, 2018 онд 859.2 мянган төгрөг болж буурсан. Харин 2019 онд нэг ажлын байр бий

болгох зардал 878.8 мянган төгрөг болж ялимгүй өссөн байна. Мөн 2020 онд нэг ажлын байр бий болгох зардал 1,485.7 мянган төгрөг болж огцом нэмэгдсэн байна.

Бий болсон ажлын байрны тоо 2016-2018 онд 4032-6637 болж огцом нэмэгдсэн, 2019 онд 6265 болж ялимгүй буурсан, 2020 онд 1598 болж огцом буурчээ.

Зураг 29. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

6.2.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр


“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэж байна. Энэ хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан ХЭДС-аар дамжуулан санхүүжүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих бодлогын хүрээнд 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах, хэрэв ажиллуулах боломжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрийг ХЭДС-д төвлөрүүлэхийг хуулийн хүрээнд шаарддаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан ХЭДС-д төвлөрүүлсэн орлого, зарцуулсан зарлагын хоорондын харьцаанд дүн шинжилгээг хийлээ.

Зураг 30-аас харахад 2016-2018 онд ХЭДС-ийн орлого нь зарцуулсан зарлагаас 3.19-6.1 дахин бага байсан бол 2019 онд уг харьцаа нь 0.96 болж орлого, зарлагын хэмжээ хоорондоо тэнцсэн байна. Харин 2020 онд орлогын хэмжээ 8,325.1 сая төгрөг огцом

нэмэгдэж, зарлагаас 2.5 дахин илүү болсон байна. Хэдийгээр 2016-2018 оны хооронд ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрөөс төвлөрсөн орлого бага байсаар байхад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан орлогоос давсан зардлыг гаргаж байсан нь төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан дэмжсэн тэгш байдлыг хангахыг зорьсон байна гэж үзэж болохоор байна. 2020 оны хувьд цар тахлын улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан ХЭДС-д төвлөрүүлсэн орлого өндөр байсан хэдий ч уг төвлөрсөн орлогын хэмжээнд хүрч зарцуулах боломжгүй байсан байна. ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрөөс төвлөрсөн орлогын хэмжээ 2019 оноос хойш огцом нэмэгдсэнээс харахад төрөөс тус орлогыг төвлөрүүлэхэд анхаарал хандуулж, орлого төвлөрүүлэх механизмыг сайжруулж, илүү их орлогыг оруулсан байж болох юм.

Зураг 30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс орох орлого, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зарлага болон эдгээрийн хоорондын харьцаа




Эх сурвалж: ХХҮЕГ

Зураг 31-ээс харахад 2016-2019 оны хооронд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо нь аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт хамрагдсан иргэдийн тооноос 4.7-14.1 дахин их буюу ХЭДС-д орлого төвлөрүүлэхээр тооцсон иргэдийн тооноос харьцангуй их хэмжээний хүн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан байна. Орлого төвлөрүүлэхээр тооцсон иргэдийн тооноос олон хүн хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авах боломж бүрдсэнээс үзэхэд төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжихэд илүү их анхаарал тавьсан, тэгш байдлыг хангахыг зорьсон байна гэж дүгнэж болохоор байна.

Харин 2020 оны хувьд уг харьцаа 1.1 буюу ХЭДС-д орлого төвлөрүүлэхэд тооцсон иргэдийн тоо болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо хоорондоо тэнцсэн байна.


Зураг 31. Аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт хамрагдсан иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо болон эдгээрийн хоорондын харьцаа



Эх сурвалж: ХХҮЕГ

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн зарлага 2016-2018 оны хооронд өсөлттэй, 2019-2020 онд ялимгүй бууралттай гарсан байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 2016-2020 оны хооронд нэг ажлын байрыг бий болгох зардал 1,096.9-3,100.9 мянган төгрөг болж жил бүр тогтмол өссөн байна. Харин бий болсон ажлын байрны тоо 2016 онд 2186 байсан бөгөөд үүнээс хойш жил бүр тасралтгүй буурсаар 2020 онд 1089 болсон байна. Зарлагын өсөлт болон бий болсон ажлын байрны тооны хоорондын хамаарлын коэффициент -0.91 буюу урвуу хамааралтай гарч байна. Өөрөөр хэлбэл, зардал нэмэгдэх чиг хандлагатай байхад бий болсон ажлын байрны тоо буурч байна.

Зураг 32. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

Эндээс дүгнэхэд тус хөтөлбөрийн үр ашиг, үр дүнгийн үзүүлэлт хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.


6.2.3.6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулах, орлогын дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зарлага 2017 он болон 2019 онд өмнөх оноосоо өсөлттэй, 2018 он болон 2020 онд өмнөх оноосоо бууралттай буюу байнгын хэлбэлзэлтэй байна. Бий болсон ажлын байрны тоо 2016-2020 онд тогтмол бууралттай буюу 2503-аас жил бүр буурсаар 2020 онд 902 ажлын байр бий болжээ.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 2016-2020 оны зарлага болон бий болсон ажлын байрны тоо хоорондын хамаарал -0.42 буюу урвуу хамааралтай гарч байгаа нь **уг хөтөлбөр үр дүн, үр ашиг хангалтгүй хэрэгжсэн гэж дүгнэх боломжтой байна.**

Зураг 33. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр



Эх сурвалж: ХХҮЕГ

6.3. Жижиг зээл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.7 дах заалт, Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор тогтоосон журмын дагуу малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг ХЭДС-аас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгож байна.

ХЭДС-аас 2016-2020 онд 4.1-20.8 тэрбум төгрөгийн жижиг зээлийг 644-1775 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгосон бөгөөд 5 жилийн дунджаар жилд 10.3 тэрбум төгрөгийн жижиг зээлийг 1102 хүнд олгосон байна.

Хүснэгт 9. Жижиг зээлтэй холбоотой үндсэн мэдээлэл


№	Жижиг зээлийн мэдээлэл	2016	2017	2018	2019	2020	Дундаж	Стандарт хазайлт
1	Нийт жижиг зээл /сая.төг/	4,114.5	12,044.5	20,813.8	6,056.7	8,546.6	10,315.2	6,575.0
2	Нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ /сая.төг/	4.1	10.8	11.7	9.4	8.9	9.0	3.0
3	Зээлдэгчийн тоо	1,014	1,112	1,775	644	964	1,101.8	415.2

Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ

Нийт жижиг зээл 2017 онд өмнөх онтой харьцуулахад 193 хувь, зээлдэгчийн тоо 10 хувь, нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ 167 хувиар тус тус өссөн байна. 2018 онд нийт жижиг зээл өмнөх онтой харьцуулахад 73 хувь, зээлдэгчийн тоо 60 хувь, нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ 8 хувиар тус тус нэмэгдсэн байна. 2020 онд нийт жижиг зээл

өмнөх онтой харьцуулбал 41 хувь өссөн, зээлдэгчийн тоо 6 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл, 2017-2018 онд болон 2020 онд нийт жижиг зээлийн өсөлтийн хурд нь зээлдэгчийн тооны өсөлт, нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээний өсөлтийн хурднаас их буюу **үр ашгийн хувьд буурсан үзүүлэлттэй** байна. Харин 2019 онд өмнөх онтой харьцуулахад нийт жижиг зээл 71 хувь, зээлдэгчийн тоо 64 хувь, нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ 20 хувь тус тус буурсан буюу нийт жижиг зээлийн бууралтын хурд нь зээлдэгчийн тооны бууралт, нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээний бууралтын хурднаас бага буюу **үр ашгийн хувьд өссөн үзүүлэлттэй** байна.

Зураг 34. Жижиг зээлийн өөрчлөлтийн хувь



Эх сурвалж: ХНХЯ

Жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн бий болгосон ажлын байрны талаар тодорхой статистик, мэдээлэл байхгүй тул уг зээлийн **үр дүнгийн үзүүлэлтийг** тодорхойлон гаргах боломжгүй байна.

6.4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ нь “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”, “Ажилд зуучлах үйлчилгээ” гэсэн хоёр үндсэн арга хэмжээнээс бүрдэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2020 онд 903225-162643 хүнийг хамруулж, 673.0-1005.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ хугацаанд уг нийтлэг үйлчилгээнд хамрагдсан нэг хүнд ногдох зардал 5,410.4-10,719.40, төгрөг байна.

Хүснэгт 10. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Дундаж	Стандарт хазайлт


Нийт зарцуулсан хөрөнгө (сая.төг)	968.2	809.1	1,005.3	1,335.4	673.0	958.2	249.1
Нийт хамрагдсан хүний тоо	90,322.0	149,545.0	133,066.0	162,643.0	84,573.0	124,029.8	35,059.6
Нэг хүнд ногдох зардал	10,719.4	5,410.4	7,554.9	8,210.6	7,957.6	7,970.6	1,893.5

Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ

Зураг 35-д үзүүлснээр 2016 онтой харьцуулахад 2017 онд уг хоёр арга хэмжээнд зарцуулсан нийт зардал 16 хувь, нэг хүнд ногдох зардал 50 хувь тус тус буурч байхад уг арга хэмжээнд хамрагдсан хүмүүсийн тоо 66 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, 2017 онд нэг хүнд ногдох зардал 5,410.4 төгрөг буюу 2016-2020 оны хооронд хамгийн бага хэмжээнд, хамрагдсан хүний тоо 149,545 буюу өмнөх оноос их хэмжээгээр нэмэгдсэн байна.

2018, 2019 онд нийт зардал 24 болон 33 хувийн өсөлттэй байхад нийт хамрагдсан хүний тоо 2018 онд 11 хувиар буурсан, 2019 онд 22 хувиар өссөн байна. Энэ нь нийт зардлын өсөлтийн хурднаас хамрагдсан хүний өсөлтийн хурд бага байгаа нь уг хоёр арга хэмжээний үр ашиг буурсныг харуулж байна. Харин 2020 онд нийт зардлын бууралт 50 хувь, нийт хамрагдсан хүний бууралт 48 хувь буюу өөрчлөлтийн хувь хэмжээ нь хоорондоо ойролцоо гарсан байна. Нийт зардлын өөрчлөлт болон хамрагдсан хүний өөрчлөлтийн хамаарлын коэффициент **0.33** буюу хамааралтай байна.


Зураг 35. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, нэг хүнд ногдох зардлын өөрчлөлтийн хувь (2016-2020)



Эх сурвалж: ХНХЯ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хоёр арга хэмжээнд 2016-2020 онд зарцуулсан хөрөнгийн задаргааг үзэхэд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д 384.1-789.2 сая төгрөгийг буюу “Ажилд зуучлах үйлчилгээ”-ээс их хөрөнгийг зарцуулсан байна.


Зураг 36. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” болон “Ажилд зуучлах үйлчилгээ”-ний зардал (сая төгрөг)



Эх сурвалж: ХХҮЕГ

“Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д 2016-2020 оны хооронд 51567-118584 хүнийг хамруулсан байна. Гэвч уг арга хэмжээнд хамрагдсан иргэдээс хэдэн хүн ажлын байртай болсон, уг сургалт, хөтөлбөр ямар үр дүнтэй байгаа талаар ямар нэг судалгаа, тооцоо, мэдээлэл байхгүй байна. Иймд уг арга хэмжээ үр дүнтэй эсэхийг дүгнэх боломжгүй байна.


Зураг 37. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д олгож буй санхүүжилт болон хамрагдсан хүний тоо, (сая төгрөг)



Эх сурвалж: ХХҮЕГ

“Ажилд зуучлах үйлчилгээ” -д 2016-2020 онд 33006-45683 хүн хамруулжээ. Харин эдгээр хүмүүс нь уг арга хэмжээнд хамрагдсанаар ажилтай болж чадсан эсэх нь тодорхойгүй тул уг арга хэмжээний үр дүнд үнэлгээ өгөх боломжгүй байна.


Зураг 38. “Ажилд зуучлах үйлчилгээ”-хамрагдсан иргэдийн тоо болон зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)



Эх сурвалж: ХНХЯ

Нэг хүнд ногдох зардлын хувьд “Ажилд зуучлах үйлчилгээ”-ний өртөг “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” өртгөөс өндөр өртөгтэй байна. Тухайлбал, 2017-2020 онд “Ажилд зуучлах үйлчилгээ”-ний өртөг 5991.3-12397 төгрөг буюу мөн үеийн “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” өртгөөс өндөр байна. Харин 2016 онд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-д хамрагдсан нэг хүнд 12102.6 төгрөг зарцуулж байсан нь “Ажилд зуучлах үйлчилгээ”-д хамрагдсан нэг хүний зардлаас өндөр байна.

Зураг 39. “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ” болон “Ажилд зуучлах үйлчилгээ”-д хамрагдсан нэг иргэнд ногдох зардлын хэмжээ (төгрөг)




Эх сурвалж: ХНХЯ

7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилтэд хийсэн үр дүн, үр ашгийн шинжилгээ

Монгол Улсад 2020 оны байдлаар нийт 80 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 50, төрийн өмчийн бус 30 сургалтын байгууллага байна. Төрийн өмчийн сургалтын байгууллагуудаас нийт 38 нь ХНХЯ-ны харьяа сургалтын байгууллагууд байгаа бөгөөд уг байгууллагууд нь 100 хувь төрөөс санхүүжиж байна. Бусад 12 төрийн өмчийн сургалтын байгууллагууд нь их дээд сургууль, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага болон тусдаа төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус төсвийн шинжилгээнд зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байгаа ХНХЯ-ны харьяа 38 сургалтын байгууллагын төсөвт дүн шинжилгээг хийлээ. **Бусад төрийн өмчийн болон төрийн өмчийн бус сургалтын байгууллагуудын төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг ХНХЯ-аас нэгтгэгддэггүй, дүн шинжилгээ хийдэггүй байна. Иймд өмчийн хэлбэрээс үл хамааран мэргэжлийн болон техникийн сургалтын байгууллагуудын төсөв, санхүүгийн тооцоо, судалгааг хүлээн авч нэгтгэдэг болох, цаашид мэргэжлийн боловсролын талаар бодлогын шийдвэр гаргах, шинэчлэлийг хийхэд санхүү, төсвийн талаар бодит мэдээлэл, өгөгдөлтэй болох хэрэгтэй байна.**

ХНХЯ-ны харьяа сургалтын байгууллагуудын нийт төсвийн үр ашгийг тооцож үзэхийн тулд 2010-2020 оны хооронд улсын төсвөөс уг сургуулиудад олгож буй нийт санхүүжилтийг суралцагчийн тоонд нь харьцуулж он тус бүрээр гаргалаа. Нэг суралцагчид ногдох зардал 2010-2020 он тогтмол өсөлттэй, тухайлбал, 2010 онд 953.0 мянган төгрөг байсан бол 2020 он 2940.1 мянган төгрөг болж даруй 3.1 дахин өссөн байна. Харин 2015 онд нэг л удаа буурсан байна.

Зураг 40. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох зардлын өөрчлөлт (мянган төгрөгөөр)



Эх сурвалж: ХНХЯ, <https://mergeil.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

Улсын төсвөөс МБТСБ-уудад олгож буй нийт төсөв (МБТСДС-ийн төсөв⁴ болон ХНХЯ-ны харьяа сургалтын байгууллагуудын төсөв)-ийг нийт сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчийн тоонд⁵ харьцуулж нэг суралцагчид ногдох зардлыг гаргалаа. Нэг суралцагчид ногдох зардал 2012 онд 1087.9 мянган төгрөг байсан бол 2020 онд 3285.3 мянган төгрөг болж 3 дахин нэмэгдсэн байна. Ялангуяа 2019, 2020 онуудад суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээг 100000 төгрөг, 200000 төгрөг болгон нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор нэг суралцагчид ногдох зардал огцом нэмэгдсэн байна.

Нэг суралцагчид мэргэжлийн болон техникийн боловсрол олгох зардал тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа хэдий ч мэргэжлийн боловсролын сургалтын чанар сайжирч буй эсэх, төгсөгчид нь тогтвортой ажлын байртай болж чадаж байгаа эсэх нь тодорхой бус байна. Иймд ХНХЯ-ны зүгээс мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын сургалтын чанарт судалгаа шинжилгээ хийх, төгсөгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарах, хөдөлмөрийн зах зээлд төгсөгчдийг тогтвортой ажлын байранд зуучлах зэргээр төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нь чухал байна.

7.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудад улсын төсвөөс олгож буй санхүүжилтийн үр дүнд хийсэн шинжилгээ

Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын төсвөөс олгож буй санхүүжилтийн үр дүнг тооцож үзэхийн тулд ажлын байртай болсон төгсөгчдийн тоог


⁴ Тэтгэлэг болон төрийн өмчийн бус сургалтын байгууллагад олгох хувьсах зардал

⁵ Төрийн болон төрийн өмчийн бус сургалтын байгууллагад суралцагчийн тоо

үндсэн үзүүлэлт болгон авч үзлээ. Мөн Төсвийн хуулийн Хавсралт 1-т нийт төгсөгчдөөс ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээг үндсэн үзүүлэлтээр баталдаг тул төсвийн үр дүнгийн үзүүлэлтийг тооцоходоо төсвийн санхүүжилт, ажлын байртай болсон төгсөгчийн тооны хоорондын хамааралд тодорхой дүн шинжилгээг хийлээ. Өөрөөр хэлбэл, уг төсвийн үр дүнгийн шинжилгээнд төсвийн санхүүжилтийг “орц”, ажлын байртай болсон төгсөгчдийн тоог “гарц” болон “үр дүн”-ийн үзүүлэлт гэж тооцоонд авсан болно.

Мэргэжлийн болон техникийн боловсролд төрөөс олгосон санхүүжилтийн хэмжээ болон ажлын байртай болсон төгсөгчийн тоог 2012-2020 оны байдлаар Зураг 41-т үзүүлээ. Төсвийн санхүүжилт болон ажлын байртай болсон төгсөгчдийн хоорондын хамаарлын коэффициент – **0.25** буюу урвуу хамааралтай гарч байгаа нь төсвийн санхүүжилтийн хэмжээ болон ажлын байртай болсон төгсөгчдийн тоо хоорондоо уялдахгүй байгааг, үр дүн хангалтгүй байгааг илтгэж байна. Тухайлбал төсвийн санхүүжилт нэмэгдэх чиг хандлагатай байхад, ажлын байртай болсон төгсөгчдийн тоо буурах чиг хандлагатай байгаа нь мэргэжлийн болон техникийн боловсролын санхүүжилт, түүний үр дүн хангалтгүй байгааг нотолж байна.


Зураг 41. Төсвийн санхүүжилт болон ажлын байртай болсон төгсөгчдийн хоорондын хамаарал (тэрбум төгрөгөөр, төгсөгчдийн тоогоор)



Эх сурвалж: СЯ, ХНХЯ <https://mergejl.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

Зураг 42-т үзүүлснээр 2013-2020 онд төсвөөс олгож буй санхүүжилтийн өөрчлөлтийн хувь болон ажлын байртай болсон төгсөгчийн өөрчлөлтийн хувь хоорондын хамаарлын коэффициент **-0.43** буюу урвуу хамааралтай гарч байна. Тухайлбал, энэ нь төсвийн зарлагын хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн буюу өсөлттэй байхад ажлын байртай болсон төгсөгчдийн тоо өмнөх оноос буурсан байна. Мөн 2013-2020 оны хоорондох 8 жилийн хугацаанд төсвийн санхүүжилт жилд дунджаар 15 хувь өсөж байсан бол ажлын байртай болсон төгсөгчдийн тоо жилд дунджаар 1.4 хувиар буурч байсан байна.

Зураг 42. Төсвөөс олгож буй санхүүжилтийн өөрчлөлт болон ажлын байртай болсон төгсөгчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар)




Эх сурвалж: СЯ, ХНХЯ <https://mergejil.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

Төсвийн санхүүжилтийн хэмжээ болон ажлын байртай болсон төгсөгчдийн тоо хоорондоо урвуу хамааралтай байгаа нь мэргэжлийн болон техникийн боловсролд төрөөс олгож буй санхүүжилтийн үр дүн хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 43-т Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй нийт санхүүжилт болон нийт төгсөгчдийн тоонд ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний хоорондын хамаарлыг 2012-2020 оноор авч үзлээ. Улсын төсвөөс олгож буй хөрөнгө болон төгсөгчдийн ажлын байртай болж буй хувь хэмжээ нь хоорондоо урвуу хамааралтай гарч байна. Тухайлбал, хамаарлын коэффициент – 0.23 буюу нийт зарлагын хэмжээ нэмэгдэж байхад ажлын байртай болж буй төгсөгчдийн нийт төгсөгчдийн тоонд эзлэх хувь буурах чиг хандлагатай гарч байна.


Зураг 43. Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй нийт санхүүжилт болон нийт төгсөгчдийн тоонд ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний хоорондын хамаарал



Эх сурвалж: ХНХЯ., <https://mergejil.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй санхүүжилтийн өөрчлөлтийн хувь хэмжээг нийт төгсөгчдөөс ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний өөрчлөлттэй харьцуулж үзэхэд мөн урвуу хамааралтай гарч байна. Хамаарлын коэффициент -0.11 буюу зарлагын өөрчлөлтийн хувь хэмжээ нэмэгдэж байхад ажлын байртай болсон төгсөгчдийн нийт төгсөгчдийн тоонд эзлэх хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй гарч байна. Өөрөөр хэлбэл, төсвийн зардал нэмэгдэж байхад төгсөгчдийн ажлын байртай болж буй тоо хэмжээ зардлын адил өсөхгүй байна. Энэ нь мэргэжлийн болон техникийн боловсролд зарцуулж буй хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй байна гэж дүгнэж болохоор байна.


Зураг 44. Мэргэжлийн болон техникийн боловсролд улсын төсвөөс олгож буй нийт санхүүжилтийн өөрчлөлтийн хувь болон нийт төгсөгчдийн тоонд ажлын байртай болсон төгсөгчдийн эзлэх хувь хэмжээний өөрчлөлтийн хувийн хоорондын хамаарал



Эх сурвалж: СЯ, ХНХЯ <https://mergejl.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

Төсвөөс олгож буй санхүүжилтийн үр дүнг нарийвчлан тооцохын тулд ХНХЯ-ны харьяа МТБСБ-д олгож буй санхүүжилтийг сургалтад хамрагдаж буй суралцагчийн тоотой харьцуулж, 2010-2020 оны хоорондох өгөгдлийг ашиглан холбогдох дүн шинжилгээг хийлээ. Төсвийн санхүүжилтийн хэмжээ болон суралцагчдын тооны хоорондын хамаарлын коэффициент **-0.76** буюу хоорондоо урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл, ХНХЯ-ны харьяа мэргэжлийн болон техникийн сургалтын байгууллагуудад олгож буй санхүүжилт жил бүр нэмэгдэж байхад суралцагчийн тоо буурсаар байна.

Зураг 45. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д олгож буй урсгал зарлага болон суралцагчдын тооны хоорондын хамаарал




Эх сурвалж: СЯ, ХНХЯ <https://mergejl.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

ХНХЯ-ны харьяа МТБСБ-д суралцагчийн тоо 2010 онд 37049 байсан бөгөөд энэ үеэс эхлэн тогтмол буурсаар 2020 онд 23272 болсон байна. Тухайлбал, суралцагчийн тоо 2010-2020 онд 37.2 хувиар буурсан байна. Мөн үед төсвийн санхүүжилт 35.3 тэрбум төгрөгөөс тогтмол өссөөр 2020 онд 68.4 тэрбум төгрөг буюу 1.94 дахин өссөн байна. Эндээс дүгнэн үзэхэд төсвийн санхүүжилтийг нэмэх тусам суралцагчийн тоо буурч байгаа нь Зураг 45-аас тодорхой харагдаж байна.

Төсвийн санхүүжилтийн өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарлын коэффициент – **0.18** буюу урвуу хамааралтай гарч байна. Төсвийн санхүүжилтийн өөрчлөлтийн хувь хэмжээ өсөж байхад суралцагчийн тооны өөрчлөлтийн хувь хэмжээ буурах чиг хандлагатай байна.

Зураг 46. Төсвийн санхүүжилтийн өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар)



Эх сурвалж: СЯ, ХНХЯ, <https://mergejil.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>
https://mlsp.gov.mn/uploads/op/files/2020-2021_statistic.pdf

Мөн 2011-2020 онд буюу сүүлийн 10 жилийн дунджаар тооцсон нэг жилд ногдох өөрчлөлтийн хувь хэмжээ нь төсвийн санхүүжилтийн хувьд 7.6 хувийн өсөлттэй, суралцагчийн тооны хувьд 4.3 хувийн бууралттай байна. Өөрөөр хэлбэл төсвийн санхүүжилтийн өсөлт нь суралцагчийн тооны өсөлтөөс илүү хурдтай байна. **ХНХЯ-ны харьяа мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа нь үр дүнгийн үзүүлэлттэй уялдахгүй, үр дүн, үр ашиг бага байгаа нь дээрх харьцуулалтаар нотлогдож байна.**

Төсвийн санхүүжилтийн үзүүлэлтээс гадна мөнгөөр илэрхийлэгдэхгүй ч төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд “орц”, “гарц”-аар тооцогдох үзүүлэлтүүдийн харилцан хамааралд холбогдох шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой юм. Энэ удаад ХНХЯ-ны харьяа МТБСБ-ын ажиллагсдын тоог “орц”-оор, суралцагчийн тоог “гарц”-аар авч тэдгээрийн хоорондын уялдаа, хамаарлыг судлан үзэж, үр дүнг шинжлэн үзлээ.


ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсдын тоо нь 2010 онд 2129 байсан бол 2020 онд 2991 болж сүүлийн 10 жилийн хугацаанд 40.5 хувиар өссөн бол, суралцагчийн тоо 2010 онд 37049 байсан бол 2020 онд 23272 болж сүүлийн 37.2 хувиар буурсан байна.

Мөн 2010-2020 оны хооронд ажиллагсдын тоо болон суралцагчийн тооны хоорондын хамаарлын коэффициент – **0.67** буюу урвуу хамааралтай буюу ажиллагсдын тоо өсөж байхад суралцагчийн тоо буурч, орцын хэмжээ өсөж байхад гарцын хэмжээ буурч байна.

Нэг ажилтанд ногдох суралцагчийн тоо мөн буурах чиг хандлагатай байгаа бөгөөд 2010 онд нэг ажилтанд ногдох суралцагчийн тоо 17.4 байсан бол 2020 онд 7.8 болж 2.2 дахин буурсан байна. Өөрөөр хэлбэл, нэг ажилтны гүйцэтгэж байгаа үүрэг, үйл ажиллагааны үр дүн буурсан гэж дүгнэж болохоор байна. Мөн нэг ажилтанд ногдох суралцагчийн тоо буурч байгаа бол сургалтын чанар, төгсөгчийн өрсөлдөх чадвар зэрэг чанарын

үзүүлэлтүүд сайжрах ёстой юм. Харин уг чанарын үзүүлэлтийг тоон утгаар илэрхийлэх, харьцуулах боломж энэ төсвийн шинжилгээнд хүрээнд хийгдэх боломжгүй байна.


Зураг 47. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсад болон суралцагчийн тооны хоорондын хамаарал (хүний тоогоор)



Эх сурвалж: ХНХЯ

ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсдын өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарлын коэффициент – **0.56** буюу урвуу хамааралтай гарч байна. Тухайлбал ажиллагсдын тооны өөрчлөлтийн хувь хэмжээ нь өмнөх онтой харьцуулахад өсөж байхад суралцагчийн тооны өөрчлөлтийн хувь хэмжээ буурч байна. Мөн 2010-2020 оны хооронд 10 жилээр тооцсон ажиллагсдын дундаж өсөлтийн хувь хэмжээ жилд 4 хувийн өсөлттэй байгаа бол, суралцагчийн дундаж өсөлтийн хувь 4.3 хувийн бууралттай байна.


Зураг 48. ХНХЯ-ны харьяа МТБСБ-д ажиллагсдын өөрчлөлт болон суралцагчийн тооны өөрчлөлтийн хоорондын хамаарал (хувиар)



Эх сурвалж: ХНХЯ

Суралцагчийн тоо болон тэтгэлгийн хэмжээ нь хоорондоо уялдаа бага байгаа нь Зураг 49-өөс харагдаж байна. Суралцагчийн тоо 2012-2020 оны хооронд буурах чиг хандлагатай байгаа бол тэтгэлгийн хэмжээ өсөх чиг хандлагатай байна. Суралцагчийн тоо болон тэтгэлгийн хэмжээний хоорондын хамаарлын коэффициент – **0.37** гарч байгаа нь урвуу хамааралтай байгааг илтгэж байна. Харин 2019 онд тэтгэлгийн хэмжээг 100000 төгрөг, 2020 онд 200000 төгрөг болгон нэмэгдүүлсэн нь суралцагчийн тоог ялимгүй нэмэгдүүлсэн байгаа нь тодорхой харагдаж байна. **Цаашид мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоо нь суралцагчдад тэтгэлэг олгох, төрөөс үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх замаар дунд болон урт хугацаанд оршин тогтнох боломжгүй юм. Иймд санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, илүү үр дүнд чиглэсэн хэлбэрт шилжихээс өөр боломжгүй байгаа нь дээр дурдсан төсөв, суралцагсдын тоо болон бусад үзүүлэлтүүдэд хийсэн дүн шинжилгээнээс тодорхой харагдаж байна.**

Зураг 49. Суралцагчийн тоо болон суралцагчид сард олгох тэтгэлгийн хэмжээний өөрчлөлтийн хоорондын хамаарал (хүний тоо, төгрөгөөр)



Эх сурвалж: ХНХЯ, legalinfo.mn

Дээр авч үзсэн мэргэжлийн болон техникийн боловсролын системийн 2010-2020 оны төсвийн зарлагын шинжилгээнд үндэслэн дүгнэж үзэхэд улсын төсвөөс мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт олгож буй санхүүжилт, дэмжлэг нь тус салбарын үр дүнтэй бүрэн уялдахгүй, үр дүн хангалтгүй гэж үзэж болохоор байна.

Дүгнэлт

Хөдөлмөрийн салбарын зарлагын шинжилгээний үр дүнд суурилан хүрсэн гол дүгнэлтийг доор дурдлаа. Үүнд:

- Хөдөлмөрийн салбарын зарлага нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, тайлагналын шатанд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, зорилтод түвшин, **үр дүнтэйгээ уялдахгүй** байна. Энэ талаар аливаа гүйцэтгэлийн аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээ төдийлөн хийгдээгүй байна. Тухайлбал, УАГ-аас Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын багцад **2017** онд хийсэн аудитын тайланд хөтөлбөрийн хэрэгжилт, хүрсэн үр дүнд товч танилцуулгыг хийсэн боловч **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрсэн үр дүн, үндсэн үзүүлэлтийн талаар ямар нэг дүгнэлт, тайлбар хийгээгүй** байна.
- СЯ-аас хөдөлмөрийн салбар болон бусад салбарын хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй холбоотой **тайлбар, танилцуулгыг** улсын төсвийн төслийн хамтаар Төсвийн хуулийн дагуу өргөн барих ёстой боловч сүүлийн 3 жилд УИХ-д холбогдох **тайлбар, танилцуулгыг** өргөн бариагүй байна.
- Төсвийн жилийн явцад болон эдийн засгийн хүндрэлтэй үед төсвийн тодотгол хийн төсвийг тодорхой хэмжээгээр бууруулж УИХ-аар батлахдаа Хавсралт 1-д туссан **хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодотгож байгаагүй**

байна. Энэ нь төсвийн зарлага нь хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүйг илэрхийлж байна.

- УИХ төсвийн хэлэлцүүлгийн шатанд **төсвийн зарлагыг хөтөлбөр, түүний үр дүнтэй уялдуулан авч үзэж, хэлэлцдэг эсэх нь тодорхойгүй байна.**
- Төсвийн хуулийн дагуу **Хөтөлбөр, түүний үр дүнг төсвийн зарлагаар тайлагнах байдал өнгөрсөн хугацаанд хангалтгүй байна.**
- Хөдөлмөрийн салбарын Хөтөлбөрүүдийн төсвийн зарлагын тооцоонд **хөрөнгийн зарлага, гадаадын зээл тусламжийг** орхигдуулж байна.
- Зарим хөтөлбөрийн зардал төсөвт **тооцогдохгүй орхигдож байна** (хөдөлмөрийн судалгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, *хөдөлмөрийн бодлого, хэрэгжилт*).
- ХХҮЕГ, орон нутаг дах ХХҮГ-ын хөдөлмөрийн салбарын Хөтөлбөрийн ангилалд хамаарах ёстой захиргаа, удирдлагын зардлыг **“Нийгмийн халамж”** хөтөлбөрт бүрэн хамаарч байна.
- Хөдөлмөрийн салбарын санхүү, төсвийн болон бусад мэдээлэл, өгөгдлийн бэлэн байдал, мэдээллийн үнэн, зөв найдвартай байдал хангалтгүй түвшинд байна.
- Бодлогын баримт бичгүүдэд туссан зорилгод түвшин, хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа **хангалтгүй** байна.

Тухайлбал, ТХЗ-2030, Алсын Хараа-2050, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, Төсвийн хуулийн Хавсралт-1, Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай”, Засгийн газрын 2016 оны 304 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилтот түвшин, хүрэх үр дүн, үндсэн үзүүлэлтийн уялдаа, биелэлт, хэрэгжилт, төсөөллөөс харахад үндсэн үзүүлэлтүүд хоорондоо уялдаа султай, хэрэгжилтийн байдалд явцын болон эцсийн үнэлгээг хийдэггүй, аливаа бодлогын шийдвэр гаргахдаа өмнөх шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, биелэлтийг харгалзаж үзээгүй ажиглагдаж байна.

- Манай улсын хөдөлмөрийн зах зээлийг дэмжихэд зарцуулсан төсвийн санхүүжилт ДНБ-ний 0.51 хувь буюу ЭЗХАХБ-ын зарим улстай харьцуулахад бага байна.
- Хөдөлмөрийн салбарын сүүлийн 12 жилийн инфляцтай уялдуулсан бодит зардлын өөрчлөлт 2010-2021 оны хооронд ялимгүй буурах чиг хандлагатай байна.
- Хөдөлмөрийн салбарын зарлагын ДНБ-д эзлэх хувь буурах чиг хандлагатай байхын хамт нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь 2010-2014 онд 2.0-2.6 хувь байсан бол 2015-2020 онд 1.2-1.9 хувь болж мөн огцом буурсан байна.
- Хөдөлмөрийн салбарын хөрөнгө оруулалтыг зориулалтаар нь авч үзвэл мэргэжлийн боловсролд зориулан зарцуулсан хөрөнгө оруулалт дийлэнх хувь, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалт харьцангуй бага хэмжээтэй байна. .

- Хөдөлмөрийн салбарын 2011-2019 оны нэг жилд ногдох зарлагын гүйцэтгэл болон төсвийн төлөвлөлтийн зөрүү дундаж хувь хэмжээ нь урсгал зарлагын хувьд **-14** хувь, хөрөнгийн зарлагын хувьд **-24** хувь, нийт зарлагын хувьд **-15** хувь байна. Энэ нь төлөвлөсөн хэмжээнд хөдөлмөрийн салбарын үйл ажиллагаа бүрэн санхүүжээгүйг харуулж байна. Цаашид төсвийг хэмнэлт, хэтрэлтийн талаар жил бүр дүн шинжилгээ хийдэг байх, өмнөх оны хэмнэлт, хэтрэлттэй харьцуулдаг байх, мөн дунд болон урт хугацааны судалгаа, шалтгааныг тодорхой судалдаг байх шаардлагатай байгаа нь харагдаж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, малчин, ахмад настан зэрэг нийгмийн тодорхой бүлгийн онцлогт тохирсон дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх, **тэгш байдлыг** хангах чиглэлийг баримталж байна гэж дүгнэж болохоор байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүн, үр ашгийг шинжлэхэд ашиглаж байгаа статистик, мэдээлэл, өгөгдлийн үнэн зөв байдал, чанарыг харгалзан үзэх шаардлага тавигдаж байна. Тухайлбал, бий болсон ажлын байр гэдгийг хэрхэн тодорхойлох, эдгээр бий болсон ажлын байр нь ямар хугацаанд тогтвортой оршин байгаа эсэх, тухайн ажлын байранд олгох цалингийн хэмжээ эсвэл олох орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэр хэмжээгээр илүү байгаа эсвэл дундаж цалингаас хэр хэмжээгээр илүү байгаа зэргийг илүү нарийвчилсан, найдвартай мэдээлэлд үндэслэн үнэн зөв гарах шаардлагатай байна.
- Одоогоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан хүмүүс болон нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүмүүс чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй, үр ашигтай дэмжлэг, үйлчилгээг батлагдсан төсвийн хэмжээ болон одоо мөрдөгдөж буй санхүүгийн дэмжлэг, зээлийн хэмжээ, нийтлэг үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдаж буй тариф, норм, нормативд хэмжээнд хангалттай авч чадаж байгаа байдалд дүгнэлт хийх боломж хомс байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн нийт төсвийн санхүүжилтийн өсөлтийн хурднаас шинээр бий болсон ажлын байрны өсөлтийн хурд бага байна. Эндээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан зарцуулсан хөрөнгийн үр ашиг хангалтгүй гэж дүгнэж болохоор байна.
- МБСБ-уудын төсөв, үр ашиг, үр дүнгийн үзүүлэлтүүд хоорондоо урвуу хамааралтай буюу үр дүн, үр ашиг хангалтгүй түвшинд байна. Нэг суралцагчид мэргэжлийн болон техникийн боловсрол олгох зардал тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа хэдий ч мэргэжлийн боловсролын сургалтын чанар сайжирч буй эсэх, төгсөгчид нь тогтвортой ажлын байртай болж чадаж байгаа эсэх нь тодорхой бус байна.
- Хувийн болон төрийн өмчийн их дээд сургуулийн харьяа МБСБ-ын төсвийг нэгтгэсэн мэдээлэл ХНХЯ-д байхгүй байна. Иймд өмчийн хэлбэрээс үл хамааран мэргэжлийн болон техникийн сургалтын байгууллагуудын төсөв, санхүүгийн тооцоо, судалгааг хүлээн авч нэгтгэдэг болох, цаашид мэргэжлийн боловсролын талаар бодлогын шийдвэр гаргах, шинэчлэлийг хийхэд санхүү, төсвийн талаар бодит мэдээлэл, өгөгдөлтэй болох хэрэгтэй байна.

ХАВСРАЛТ 1. ТХЗ, “АЛСЫН ХАРАА-2050”, ТӨСВИЙН ХАВСРАЛТ 1 ДЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ

№	ТХЗ-ын Зорилго, хүрэх үр дүн	ТХЗ-ын Үзүүлэлт	Алсын Хараа-2050-ын Үзүүлэлт	Төсвийн хуулийн Хавсралт 1-ийн үзүүлэлт
1	Зорилт 8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих	8.3.1 Хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлтэд албан бус секторын ажил эрхлэлтийн эзлэх хувь, хүйсээр		
2	Зорилт 8.5 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнтэй ажилд адилхан цалин хөлс олгох	8.5.1 Эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж хөлс, ажил мэргэжлээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр	28. Ажилгүйдлийн түвшин	27.5.1. Ажилгүйдлийн түвшин /хувиар/
		8.5.2 Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр		
3	Зорилт 8.6 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах	8.6.1 Боловсрол эзэмшээгүй, хөдөлмөр эрхлээгүй болон сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь		
4	Зорилт 8.7 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох	8.7.1. Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр		
5	Зорилт 8.8 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүх ажил хөдөлмөр эрхлэгчид, түүний дотор улирлын түр ажилтан, ялангуяа улирлын түр эмэгтэй ажилтан, аюултай хөдөлмөр эрхэлдэг ажилтнуудад аюулгүй, найдвартай ажиллах орчныг бий болгох	8.8.1. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь, хүйсээр, цагаачлалын байдлаар		27.7.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр шинэчлэн боловсруулах дүрэм, журам, стандартын тоо
		8.8.2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж болон үндэсний хууль тогтоомжид үндэслэн гарах эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээртэй холбоотой хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн түвшин		
				27.7.2. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн ажлын байрын тоо

				27.8.1. Хөдөлмөрийн салбарын хүрээнд хийсэн судалгааны тоо
6	Зорилт 8.b 2020 он гэхэд залуучуудын ажил эрхлэлтийн дэлхийн стратегийг боловсруулан хэрэгжүүлж, ОУХБ-ын Ажил хөдөлмөрийн дэлхийн гэрээ хэрэгжүүлэх	8.b.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний стратегийн хүрээнд эсвэл тусад нь боловсруулан хэрэгжүүлж байгаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний стратегитай эсэх		
7	Зорилт 10.1 2030 он гэхэд бага орлоготой хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр түвшинд аажмаар хүргэж, хадгалах	10.1.1 Хүн амын нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн хүн амын орлого, зарлагын эзлэх хувийн жингийн өөрчлөлт (өсөлт)	21. Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь	
8	Зорилт 10.4 Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах	10.4.1 ДНБ-нд цалин, нийгмийн хамгааллын шилжүүлгийн эзлэх хувь		
9			9. Нийт төгсөгчид ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль)	27.6.1. Мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөгчдийг ажлын байраар хангах /хувиар/
10			26. Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	
11			27. Ажиллах хүчний оролцооны түвшин	
12				27.5.2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/
13				27.5.3. Шинээр бий болсон ажлын байрын тоо /мянган хүн/

Ашигласан Материал

Улсын Их Хурал. (2020). “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. <https://www.legalinfo.mn/annex/details/11059?lawid=15406>

Засгийн Газар. (2016). Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр. <https://www.legalinfo.mn/law/details/12062>

Засгийн газар. (2016). Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого. <https://www.legalinfo.mn/law/details/12035>

Төсвийн тухай хууль. (2011).

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2020). Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн Хавсралт 1. (2020). <https://www.legalinfo.mn/annex/details/11371?lawid=15726>

Үндэсний Аудитын Газар. (2018). Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. <https://tailan.audit.mn/api/pages/f28290a09c49e7a6fbbeb978b9f7dc066/watermarked.pdf>

Үндэсний Аудитын Газар. (2019). Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. <https://audit.mn/wp-content/uploads/2020/09/Tuswiin-guitsetgel.pdf>

Үндэсний Аудитын Газар. (2020). Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. <https://audit.mn/wp-content/uploads/2020/09/2019-negdsen-guitsetgel.pdf>

Үндэсний Аудитын Газар. (2017). Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт. <http://forum.parliament.mn/projects/221>

Үндэсний Аудитын Газар. (2018). Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт.

Үндэсний Аудитын Газар. (2020). Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт.

Үндэсний Аудитын Газар. (2017). Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит. <https://www.shilendans.gov.mn/org/7619?form=1534644&year=2016&month=12&group=0&task=7706>

Үндэсний Аудитын Газар. (2018). Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит. <https://www.shilendans.gov.mn/org/7619?form=2370994&year=2017&month=12&group=0&task=7706>

Үндэсний Аудитын Газар. (2019). *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит.*

<https://www.shilendans.gov.mn/org/7619?form=3079763&year=2018&month=12&group=0&task=7706>

Үндэсний Аудитын Газар. (2020). *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит.*

<https://www.shilendans.gov.mn/org/7619?form=3998641&year=2019&month=12&group=0&task=7706>

Үндэсний Статистикийн Хороо. *Тогтвортой Хөгжлийн Зорилго.*

<https://sdg.1212.mn/#goal3>

Үндэсний Статистикийн Хороо. *Тогтвортой Хөгжлийн Зорилго, Зорилго 8. Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих.*

<https://sdg.1212.mn/Home/Detail?id=8>

Үндэсний Статистикийн Хороо. *Хэрэглээний үнийн түвшин.*

https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L06&type=tables

Үндэсний Статистикийн Хороо. *Ажилгүй хүн, Ажилгүйдлийн түвшин, Хөдөлмөр*

эрхлэлтийн түвшин. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_006V1

Үндэсний Статистикийн Хороо. *Дотоодын нийт бүтээгдэхүүн.*

https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0500_001V1

А.Заяадэлгэр, С.Эрдэмчимэг. (2020). *Боловсролын салбарын төсвийн зарлагын хандлагын шинжилгээ.* Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлб.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2020). *Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл, 2020-2021 оны хичээлийн жил.*

https://mlsp.gov.mn/uploads/files/2020-2021_statistic.pdf,

<https://mergejil.mn/uploaded/documents/2020/October/2019-2020%20statistic%20nom.pdf>

IMF.(2017). *Extended arrangement under Extended Fund Facility (EFF) for Mongolia.*

Washington, DC: International Monetary Fund.

OECD. (2018). *Public Spending on Labor Markets.* <https://data.oecd.org/social/exp/public-spending-on-labour-markets.htm>

Public Expenditure and Financial Accountability. (2016). *PEFA Framework for assessing public financial management.* PEFA Secretariat Washington, DC.

https://gbdrrf.org/system/files/privatefiles/public_financial_management_performance_measurement_framework_0.pdf

World Bank. (2018). *Mongolia Economic Update.* Washington, DC: World Bank.

